2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## **ОЙГООС МОД ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх, Сэлэнгэ аймгийн ойгоос /цаашид ойгоос гэх/ мод шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг тус аймгийн ойн сангаас өөр аймаг болон нийслэлд мод шилжүүлэн суулгах ойн мэргэжлийн байгууллага болон аймаг дотроо ашиг олох зорилгогүйгээр мод шилжүүлэн суулгах гэж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.

1.3.Бусад аймаг, нийслэлийн, хот суурингийн нийтийн эзэмшлийн талбайд шилжүүлэн суулгах модыг тухайн аймаг, нийслэлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй, дадлага туршлагатай мэргэжлийн боловсон хүчин, зориулалтын техник хэрэгсэл бүхий ойн мэргэжлийн байгууллагад өгнө.

1.4.Орон нутгийн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиг олох зорилгогүйгээр хувийн хэрэгцээнд тарихаар 10 ширхэг, нийтийн эзэмшлийн талбайд тарихаар 30 ширхэгээс илүүгүй модыг шилжүүлэн суулгах ажлыг гүйцэтгэж болно.

1.5.Ойгоос модыг дараах зориулалтаар шилжүүлэн суулгахыг зөвшөөрнө. Үүнд:

1.5.1.Хот, суурин газар, тусгай объектыг цэцэрлэгжүүлэх

1.5.2.Ойн зурваст тарих

1.6.Түймрээс хамгаалах ойн зурвас, өндөр хүчдэлийн шугамын доорх зурвас газар, уурхайн эдэлбэрт орсон талбай, мөн шигүү ургасан ойн арчилгаа хийх шаардлагатай талбайгаас модыг шилжүүлэн суулгана.

Хоёр. Ойгоос мод шилжүүлэн суулгах зөвшөөрөл олгох

2.1.Иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойгоос мод шилжүүлэн суулгах хүсэлтээ Ойн ангиар гаргуулсан дүгнэлтийн хамт аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бичгээр ирүүлнэ. Хүсэлтэд ойгоос шилжүүлэн суулгах модны төрөл, тоо, өндөр, нас, зориулалт, шилжүүлэн суулгах газрын талаарх мэдээллийг тус тус тусгасан байна.

2.2.Сумын болон сум дундын Ойн анги нь ойн менежментийн төлөвлөгөө, ой зохион байгуулалтын материалыг үндэслэн хаанаас мод авах, нөөц байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

2.3.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь ойгоос мод шилжүүлэн суулгах зөвшөөрөл олгохдоо Ойн ангийн гаргасан дүгнэлт, ойн мэргэжлийн байгууллагын өмнөх жилүүдэд гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын гүйцэтгэлийг үндэслэж шийдвэр гаргана.



2.4.Ойгоос мод шилжүүлэн суулгах модны төлбөрийн 50 хувийг тухайн мод авч буй суманд, 50 хувийг аймгийн “Байгаль хамгаалах сан”-д урьдчилан төлнө.

#### Гурав. Мод шилжүүлэн суулгах гэрээ байгуулах

3.1.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зөвшөөрөл авсан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн сумын Засаг даргатай мод шилжүүлэн суулгах гэрээ байгуулна.

3.2.Ойгоос мод шилжүүлэн суулгах гэрээнд дараах зүйлийг тусгана. Үүнд:

3.2.1.Мод шилжүүлэн суулгах үндэслэл, зориулалт

3.2.2.Мод авах газрын нэр, таксацийн бичлэг /ойн нөөцийг судлан тооцож, чанарын ба тоон үзүүлэлтийг тогтоох, үнэлэх техник үйл ажиллагаа/ төрөл, тоо, өндөр, нас

3.2.3.Шилжүүлэн суулгах модны үнэ, нөхцөл

3.2.4.Гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг хамтран хүлээх хариуцлага

3.2.5.Мод шилжүүлэн суулгах технологи

3.2.6.Мод авах, тээвэрлэж дуусах хүртэлх хугацаа

3.3.Гэрээ нь тухайн гэрээнд заагдсан хугацаандаа хүчинтэй байх бөгөөд талууд харилцан тохиролцсноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

#### Дөрөв. Мод шилжүүлэх явцад тавих хяналт

4.1.Тухайн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нь “Мод шилжүүлэн суулгах гэрээ”-ний дагуу ойгоос мод авах, шилжүүлэн тээвэрлэх явцад байнгын хяналт тавих үүрэг хүлээнэ.

4.2.Мод шилжүүлэн суулгах гэрээний биелэлтэнд оролцогч талууд харилцан хяналт тавьж ажиллана.

4.3.Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нь “Мод шилжүүлэн суулгах гэрээ”-нд заасан шилжүүлэн суулгах модны тоо хэмжээ дуусмагц сумын Засаг даргад мэдэгдэнэ.

4.4.Сумын болон сум дундын Ойн анги нь ойн мэргэжлийн байгууллагын ойгоос шилжүүлэн суулгахаар авсан модны тоо хэмжээг нэгтгэн мэдээллийн сан бий болгож зохих мэдээллийг тухайн сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хагас, бүтэн жилээр ирүүлнэ.

#### Тав. Хориглох зүйл, хүлээлгэх хариуцлага

5.1.Ойн тухай хуулийн 14.1-д заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос мод шилжүүлэн суулгахыг хориглоно.

5.2.Гэрээнд заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү мод авсан зэрэг тохиолдолд дахин мод шилжүүлэн суулгах зөвшөөрөл олгохгүй.

5.4.Зөвшөөрөлгүйгээр ойгоос мод авсан, тээвэрлэсэн, худалдан борлуулсан, шилжүүлэн суулгах модыг заасан газраас аваагүй зэрэг тохиолдлуудад Ойн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
75 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ОЙГООС 1 ШИРХЭГ** МОД ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮНЭЛГЭЭ  
/Мян.төг/

№	Модны төрөл	Модны өндөрийн хэмжээ /метр/				
		<1	1-2	2-3	3-4	4-5
1	Шилмүүст мод	5,0	10,0	15,0	20,0	25,0
2	Навчит мод	3,0	6,0	9,0	12,0	15,0

Тайлбар: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 394 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Нэг ширхэг зулзган, залуу модны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ний 10%-аар тооцож ойгоос 1 ширхэг мод шилжүүлэн суулгах үнэлгээг гаргав.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫНТОГТООЛ

2015 оны 12 сарын 04-ны өдөр Дугаар 76

Сүхбаатар

### Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2-д, “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Ойгоос мод шилжүүлэн суулгах журам”-ыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн ИТХ-ын 2015 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг “Байгаль хамгаалах сан”-д төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлд дараах заалтуудыг нэмж оруулсугай. Үүнд:

*2.1.9. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого*

*2.1.10. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого*

*2.1.11. Ойгоос мод шилжүүлэн суулгах төлбөрийн орлогын 50 хувь*

*2. Дээрх заалтуудыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.*

*3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/-д даалгасугай.*

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫНТОГТООЛ

2015 оны 12 сарын 04-ны өдөр Дугаар 77

Сүхбаатар

### Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “в”-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Ноён уул орчмын газар нутгийн Улсын тусгай хамгаалалтад хамруулах асуудлыг нарийвчлан судалж санал боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

С.Бүрэнбат- Аймгийн Засаг дарга

Гишүүд:

М.Баярбаатар - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, үйлдвэр, хөдөө аж ахуйн бодлогын хорооны дарга

С.Энхтайван- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь

Ардчилсан намын бүлгийн дарга

Б.Баярхүү- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Б.Цээпилдорж- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Ж.Баярмагнай- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Б.Энхбат- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Ж.Отгонхүү- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Б.Батзориг- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Хоёр. Судалж боловсруулсан саналаа 2015 оны 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн  
77 дугаар тогтоолын хавсралт

## **НОЁН УУЛ ОРЧМЫН ГАЗРЫГ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАНД АВАХ АСУУДЛААР САНАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Ажлын хэсэг 2015 оны 12 дугаар сарын 02 дугаар 10 хоногт Мандал суманд 3 хоногийн хугацаатай ажиллаж доорхи ажил үүргийг гүйцэтгэнэ.

1.Мандал сумын ИТХ, Засаг даргатай уулзаж санал солилцон тус сумын ИТХ-аас гаргасан шийдвэрийн үндэслэл, шалтгаан ач холбогдлыг тодруулах

2.Ноён уул, Гачууртын ам орчимд нутаглан амьдардаг айл өрх, өвөлжөө, хаваржааны хашаа хорооны тоо, бэлчээр нутгийн хэмжээ

3.Тус сумын иргэд ялангуяа Ноён уулын орчимд нутаглаж байгаа иргэд, малчидтай уулзаж саналыг сонсох, тухайн нутгийг улсын тусгай хамгаалалтанд авсанаар тэдний ахуй амьдрал, аж ахуй эрхлэлтэнд эерэг болон сөргөөр нөлөөлөх зүйлүүдийн талаар ярилцах. /Хуулинд юу гэж заасан байгааг үндэслэл болгох/

4.Ноён уул орчмын газрыг тусгай хамгаалалтанд авах эрдэмтэн судлаачдын санал болгож байгаа 33850 га, Засгийн газар БОНХАЖЯ-ны санал болгож байгаа 11194.2 га, Мандал сумын ИТХ-аас санал болгож байгаа 904 га талбай түүний хилийн цэсийг газар дээр нь үзэж харьцуулан дүгнэлт хийх. Энэ нь:

-Гачууртын алтны ордыг ашиглах Засгийн газрын бодлоготой нийцэж байгаа эсэх

-Ноён уулын түүх соёлын дурсгалыг хамгаалах талаар эрдэмтэн судлаачид болон иргэний нийгмийн зарим байгууллагуудын саналтай уялдаж байгаа эсэх

-Нутгийн иргэдийн аж амьдрал, аж ахуй эрхлэлтэнд эерэг сөрөг ямар нөлөө үзүүлэхээр байгаа

-Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэл юу байгаа зэргийг тодруулан дүгнэлт гаргах

5.Ноён уул орчмын газар нутагт хэдэн аж ахуйн нэгж, иргэний хэдэн га ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын лицензтэй талбай байгаа, тэдгээрээс тусгай хамгаалалтанд авахаар санал болгож байгаа:

-33850 га-д хэдэн аж ахуйн нэгжийн хэдэн га лицензтэй талбай, хэдэн булш хиригсүүр, хэдэн өвөлжөө, хаваржаа, уст цэг хамрагдаж байгаа

-11194.2 га-д хэдэн аж ахуй нэгжийн хэдэн га лицензтэй талбай, хэдэн булш хиригсүүр, хэдэн өвөлжөө, хаваржаа, уст цэг хамрагдаж байгаа

-Мандал сумын санал болгож буй 904 га-д хэдэн ААН-ийн хэдэн га лицензтэй талбай, өвөлжөө, хаваржаа, уст цэг хамрагдаж байгаа

6.Гачууртын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлтэй танилцах /холбогдох албаны хүмүүстэй уулзах замаар/ Ноён уулын Гачууртын ордыг ашигласнаар улсын эдийн засагт, аймгийн болон Мандал сумын хөгжил, ард

иргэдийн аж амьдралд ямар үр өгөөж өгөх вэ гэсэн асуултанд хариулт авах  
7.Ноён уул орчимд хууль бусаар алт олзворлож байгаа болон түүнтэй  
тэмцэж байгаа байдалтай газар дээр нь танилцах

Бэлтгэж авч явах материалууд:

а/.Ноён уул орчмын газар нутгийг өмнө нь орон нутгийн тусгай  
хамгаалалтанд авч байсан болон улсын тусгай хамгаалалтанд авахаар  
Засгийн газарт уламжилж байсан аймаг, сумын ИТХ-ын шийдвэрүүд

б/.Орон нутгийн тусгай хамгаалалтаас гаргаж байсан мөн  
байгууллагуудын шийдвэрүүд

в/.Гачууртын орд газрыг ашиглахыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн ард  
иргэдийн төлөөллөөс аймаг, сум, УИХ, Засгийн газарт ирүүлсэн санал  
гомдлууд /хэрэв байвал/

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫНТОГТООЛ**

2015 оны 12 сарын 04-ны өдөр Дугаар 78

Сүхбаатар

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төлбөр хураамжийн хэмжээ тогтоох тухай Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 66 дугаар тогтоолын үндэслэл хэсэгт “Хууль зүйн сайдын 2015 оны 02 сарын 25-ны өдрийн Журам батлах тухай А/30 дугаар тушаалыг” гэснийг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг” гэж өөрчилсүгэй.

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 01 сарын 06-ны өдөр Дугаар 09

Сүхбаатар

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлогын 4.2.9-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээнд тусгах асуудлын талаар хэлэлцээр хийх ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

1. Ажлын хэсгийн ахлагч: -Б.Цээпилдорж /аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/ Гишүүд:

- Б.Баярхүү /аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/
- Г.Бямбаа /аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/
- Г.Батцэнгэл /аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/
- Ч.Даваасүрэн /аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/

2. Ажлын хэсгийн ажиллах чиглэлийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Гэрээ байгуулах ажлын явц, талуудаас тавьж буй саналууд, байр суурийн талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тухай бүр танилцуулж удирдамж чиглэл авч, гэрээний төсөлд тусгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Цээпилдорж/-д даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 06-ны  
өдрийн 09-ний өдрийн тогтоолын хавсралт

**Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй хэлэлцээр  
хийх ажлын хэсгийн удирдамж**

Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуй нэгжүүдтэй нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний төсөлд тусгах асуудлын талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлж хэлэлцээр хийх ажлын хэсэг нь энэ удирдамжид заасан ажил үүргийг хэрэгжүүлнэ.

Тус аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуй нэгжүүдийн удирдлагууд /Ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, ТУЗ, орон нутаг хариуцсан захирал г.м/-тай уулзалт ярилцлага хийж санал солилцох,

Нэг. Санал солилцож хэлэлцээр хийхдээ доорх асуудлуудыг хөндөж ярилцана.

-Аймгийн болон тухайн уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй сумын удирдлагуудтай уулзаж гэрээнд тусгах саналыг сонсож ярилцах,

-Аймаг орон нутгийн хөгжлийг дэмжих санд тухай аж ахуйн нэгжээс оруулах хөрөнгийн хувь хэмжээ, нөхцлийг тохиролцох,

-Уурхайг хэрхэн яаж ашиглах, байгаль орчинд халгүй, хүн малд аюулгүй технологи хэрэглэх, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх талаар,

-Уурхай ажиллуулах, баяжуулах, боловсруулах үйлдвэр болон орон нутагт шаардлагатай бусад үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтэц /зам харилцаа, холбоо, цахилгаан, дулаан г.м/-ийг хөгжүүлэх, бий болгох талаар,

-Орон нутагт ажлын байр бий болгох, тухайн орон нутгаас ажиллуулах иргэдийн хувь хэмжээний талаар,

-Орон нутгийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт хийх талаар,

-Өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил үйлчилгээ, худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа шаардлага хангасан аж ахуй нэгж, байгууллагад давуу эрх олгох нөхцөл боломжийн талаар,

Хэлэлцээр хийсэн тухай бүр талуудаас гаргасан санал, ярилцан тохиролцсон асуудлын талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан удирдамж чиглэл авч ажиллана.

-Хэлэлцээрээр гэрээнд тусгахаар тохиролцсон асуудлыг гэрээ байгуулагч талуудад албан бичгээр мэдэгдэж гэрээнд тусгуулан хяналт тавьж ажиллах.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21-ний өдөр Дугаар 11

Сүхбаатар

**Төлөвлөгөө батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын  
21-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2015 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Тухайн жилд дэвшүүлсэн зорилт

1.Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл зохион байгуулалт, хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийн боловсруулалтын чанар үр өгөөжийг сайжруулах

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хурлаас батлан гаргасан дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилт биелэлтийн явц байдал, үр дүнг тооцон үнэлгээ өгөх

3.Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан аймаг, сумдын төсвийн боловсруулалт, хуваарилалтыг бодитой тооцож үндэслэлийг сайжруулах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд Хурлаас тавих хяналтыг тогтмолжуулах

4.Аймгийн хэмжээнд уул уурхайн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг орон нутгийн хөгжилтэй уялдуулж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэн, аймаг орон нутагтай хамтран ажиллах сонирхлыг нэмэгдүүлж ард иргэдэд хүртээмжтэй, харилцан ашигтай хариуцлагатай уул уурхайг хөхүүлэн дэмжих,

5.Төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд Хурлаас тавих хяналт бодлого шийдвэрээр дэмжих.

### Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

№	Хэлэлцэх асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан		
	Аймгийн ИТХ-ын XII хуралдааны бэлтгэлийг ханган хэлэлцүүлэх	II сард	Тэргүүлэгчид
1.1	Аймгийн 2015 оны төсвийн тодотгол		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, аймгийн ЗДТГ-ын СТСХ
1.2	Аймгийн Байгаль орчныг хамгаалах сангийн журмын төсөл		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, БОАЖГ

Аймгийн ИТХ-ын XIII хуралдааны бэлтгэлийн ханган хуралдуулж доорх асуудлуудыг хэлэлцүүлнэ		IV сард	Тэргүүлэгчид
1.2.1	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ЗДТГ
1.2.2	Сэлэнгэ аймгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, аймгийн ЗДТГ-ын СТСХ
1.2.3	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх тухай		Аймгийн ГХБХБГ
1.2.4	Таван хошуу малын татварын хувь хэмжээг тогтоох тухай		Аймгийн ЗДТГ-ын СТСХ
Аймгийн ИТХ-ын XIV хуралдааны бэлтгэлийн ханган хуралдуулж доорх асуудлуудыг хэлэлцүүлнэ			Тэргүүлэгчид
1.3.1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	IX сард	Аймгийн БОГ, Татварын хэлтэс
1.3.2	Аймгийн хэмжээнд усан хангамж, ариутгах татуургын баримтлах бодлогын тухай		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ХБХ
1.3.3	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын төсөл		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ХБХ
Аймгийн ИТХ-ын XV хуралдааны бэлтгэлийн ханган хуралдуулж доорх асуудлуудыг хэлэлцүүлнэ		XII сард	Тэргүүлэгчид
1.4.1	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт, 2016 оны Үндсэн чиглэлийн төсөл		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ЗДТГ
1.4.2	Аймгийн 2016 оны төсвийн төсөл		Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, СТСХ
1.4.3	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны ажлын тайлангийн тухай		Ж.Санжжав
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд			
Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдааныг сард 1-ээс доошгүй удаа бэлтгэлийн ханган хуралдуулж доорх асуудлуудыг хэлэлцэнэ.		Сар бүр	Тэргүүлэгчид

	“Улсын сайн малчин”, “Улсын Тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын Тэргүүний тариаланч”-ийг шалгаруулан шагнуулахаар МУ-ын Засгийн газарт уламжлах	I сард	Тэргүүлэгчид
2.1	Аймгийн ИТХ-ын 2015 оны ажлын төлөвлөгөө	I сард	Ж.Санжжав, Э.Оюунболд
2.2	2015 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай	I сард	Аймгийн ГХБХБГ
2.3	Сэлэнгэ аймагт хийгдсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тухай	I сард	Аймгийн ЗДТГ-ын ХБХ, БОАЖГ
2.4	“Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийн төсөл	II сард	Нийгмийн бодлогын хэлтэс
2.5	2015 онд агнах барих амьтны тоо тогтоох тухай		БОАЖГ
2.6	“Сэлэнгийн долгио чуулга”-ын уран сайхны бодлого чиглэл, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээлэл		Нийгмийн бодлогын хэлтэс, Сэлэнгийн долгио чуулга
2.7	“Малын тэжээл” /2009-2014/ хөтөлбөрийн биелэлт үр дүнгийн тухай		Аймгийн ЗДТГ-ын ХБХ, ҮХААГ
2.8	“Загас” аймгийн хөтөлбөрийн төсөл		Аймгийн ҮХААГ
2.9	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2014 оны ажлын тайлан	III сард	ОНӨААТҮГ-ууд, ажлын алба
2.10	“Сургалтын чанар” /2010-2014/ хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн тухай		Аймгийн ЗДТГ-ын НБХ, БСГ
2.11	“Эрүүл хот, сум, баг ажлын байр” хөтөлбөрийн төсөл		Аймгийн ЗДТГ-ын НБХэлтэс
2.12	Орон нутгийн байгууллагыг Гавьяат үйлстний нэрэмжит болгоход мөрдөх журмын төсөл	IV сард	Тэргүүлэгчид, ажлын алба
2.13	“Сэлэнгэ цэвэр орчин” /2009-2014/ хөтөлбөрийн биелэлт үр дүнгийн тухай		Аймгийн ЗДТГ-ын НБХэлтэс
2.14	Мал төллөлтийн байдал, хаврын тариалалтын талаарх мэдээлэл		Аймгийн ҮХААГ

2.15	“Сэлэнгэ аймагт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгох журам”-ын шинэчилсэн төсөл	V сард	Аймгийн ЗДТГ-ын ХБХ
2.16	“Архидалттай тэмцэх хөтөлбөр”-ийн төсөл		Аймгийн ЗДТГ-ын ХЗХ
2.17	“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын шинэчилсэн төсөл		Аймгийн ЗДТГ-ын ХЗХ
2.18	“Нийгмийн дэг журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” /2010-2014/ хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн тухай	VII сард	Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс
2.19	Аймгийн аялал жуулчлалын бүсийг тогтоох, аялал жуулчлалын бүсэд мөрдөх журмын төсөл		Аймгийн ЗДТГ, БОАЖГ
2.20	Хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, шинэ ажлын байр нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл	VIII сард	Хөдөлмөрийн хэлтэс
2.21	Хүүхэд хамгаалах стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн талаарх мэдээлэл /2012-2015/		Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс
2.22	Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалтыг батлах, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид шилжүүлэх журмын төсөл	2-р улирал	Тэргүүлэгч Г.Бямбаа, Орон нутгийн өмчийн алба
2.23	Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын талаарх мэдээлэл	IX сард	Аймгийн Боловсрол соёлын газар
2.24	Аймгийн “Ахуй үйлчилгээ” хөтөлбөрийн төсөл		Аймгийн ЗДТГ-ын ХБХ
2.25	Хөгжлийн бодлогын салбарт хэрэгжиж буй аймгийн хөтөлбөрүүдийн явцын мэдээлэл	X сард	Аймгийн ЗДТГ-ын ХБХ
2.26	“Экологийн боловсрол” аймгийн хөтөлбөрийн төсөл	X сард	Аймгийн ЗДТГ, БОАЖГ
2.27	“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний явц, үр дүнгийн мэдээлэл	XI сард	Аймгийн ЗДТГ-ын ХЗХ
2.28	Намрын ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл байдлын талаарх мэдээлэл		Аймгийн ҮХААГ

2.29	Цагдаагийн байгууллагад олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл	XII сард	Иргэний зөвлөлийн дарга О.Буянтогтох
2.30	Сумдын эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, эргэлтийн эмийн сангийн зарцуулалтын талаарх мэдээлэл		Аймгийн ЗДТГ-ын НБХ, ЭМГ
3. Хяналт шалгалтын ажил			
3.1	Сумдын ИТХ-ын 2014 оны ажлын тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийх	1-р сард	Ажлын алба
3.2	Сумдын ИТХ, БИНХ түүний Тэргүүлэгчдийн ажлыг шалган танилцаж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх	Жилдээ	Ажлын алба
3.3	Амарбаясгалант хийдийн үйл ажиллагааны менежмент, өмчийн харъяалал, хийд орчмын айл өрх, аялал жуулчлалын баазуудын оновчтой байршлын асуудлыг судалж танилцан санал боловсруулах	1-р улиралд	Тэргүүлэгчид аймаг, сумын ЗДТГ-тай хамтарч
3.4	“Зөвшөөрөлгүйгээр атар газар хагалахыг хориглох тухай” аймгийн ИТХ-ын 2010 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдлыг зарим сумдад шалган танилцах	2-р улиралд	Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
3.5	Сургуулийн өмнөх боловсролын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг зарим цэцэрлэгийн үйл ажиллагаанд шалган танилцах	2-р улиралд	Нийгмийн бодлогын хороо
3.6	Бичил уурхайн үйл ажиллагаанд Хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалган танилцах	3-р улиралд	Нутгийн удирдлага, хууль хяналтын бодлогын хороо
3.7	Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалган танилцах	2-р улиралд	Тэргүүлэгчид, Эдийн засаг, төсвийн бодлогын хороо
3.8	Татварын орлогын бүрдүүлэлтийн байдлыг 2-оос доошгүй суманд шалган танилцах	3,4-р улиралд	Эдийн засаг, төсвийн бодлогын хороо
3.9	“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллах	Тухай бүр	Тэргүүлэгчид
4. Судалж боловсруулах асуудал			

4.1	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулах	1-р улиралд	Ж.Санжжав, Э.Оюунболд
4.2	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Засаг даргаас батлан гаргах бодлогын баримт бичгийг боловсруулж шийдвэрлүүлэхэд баримтлах журмын төсөл боловсруулж батлуулах	1-р улиралд	Э.Оюунболд, Хууль зүйн хэлтэс
4.3	Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалтыг гаргах, Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид шилжүүлэх журмын төсөл боловруулах	2-р улиралд	Тэргүүлэгч Г.Бямбаа Орон нутгийн өмчийн алба
4.4	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф үндэслэлтэй эсэхийг судалж дүгнэлт гаргах	2-р улиралд	Тэргүүлэгчид, ажлын алба
4.5	Орон нутгийн байгууллагыг Гавьяат үйлстэний нэрэмжит болгоход мөрдөх журмын төслийг боловсруулах	3-р улиралд	Тэргүүлэгчид, ажлын алба
4.6	Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх ажлын хүрээнд аймгийн төсвийн байгууллагуудаас иргэн, аж ахуйн нэгжүүдэд үзүүлж байгаа үйлчилгээний журам, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд судалгаа хийж дүгнэлт гаргах	3-р улиралд	Тэргүүлэгчид, ажлын алба
4.7	ЕТГ, УИХ, Засгийн газраас санаачлан бүх нийтээр хэлэлцүүлж байгаа зарим хуулийн төсөлд санал өгөх, орон нутаг иргэдээс санал авч нэгтгэн боловсруулж хүргүүлэх	Тухай бүр	Ажлын алба
4.8	Сэлэнгэ аймгийн 9 гайхамшигийг иргэдийн санал асуулгаар тодруулах ажлыг зохион байгуулан Хурлын шийдвэрээр баталгаажуулах	3-р улиралд	Ажлын алба
5. Орон нутаг, иргэдтэй ажиллах талаар			



5.1	Тэргүүлэгчид бүрэн бүрэлдэхүүнээрээ зарим сум багийн ажил амьдралтай танилцаж, иргэдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсох		Тэргүүлэгчид
	· Орхон, Сант	2-р улиралд	
	· Ерөө, Алтанбулаг	4-р улиралд	
5.2	Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, хүн амд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр өгөөжийн талаар Мандал, Сайхан сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шалган танилцах	2-р улиралд	Тэргүүлэгчид
5.3	Тэргүүлэгчид Сэлэнгэ аймгийн Хил хамгаалах байгууллага, Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай танилцах	3-р улиралд	Тэргүүлэгчид
5.4	Хүдэр сум дахь Төмөртэйн орд газрын уул уурхайн үйл ажиллагаатай танилцах	3-р улиралд	Тэргүүлэгчид
5.5	Аймаг, сумын Хурлын Төлөөлөгчдийн өдөрлөг нэгдсэн удирдамжаар зохион байгуулж иргэдэд Төлөөлөгчийн ажлын тайланг тавиулж Хурлын шийдвэр үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч санал хүсэлтийг сонсох	4-р улиралд	Ажлын алба
5.6	Аймгийн ИТХ-ын дэргэдэх Ахмад зөвлөхүүдийн багаар Хурал, Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэх асуудал болон аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Тухай бүр	Аймгийн ИТХ-ын дэргэдэх Ахмад зөвлөхүүдийн баг, Ажлын алба
5.7	Иргэний танхимаар хэлэлцүүлэх асуудлаар байгууллагуудаас санал авч хэлэлцүүлэг зохион байгуулах	Тухай бүр	Ажлын алба
6. Мэдээлэл, сурталчилгааны ажил			
6.1	Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2014 онд батлан гаргасан тогтоол, шийдвэрийг эмхэтгэл болгон хэвлүүлэх	1-р улиралд	Ажлын алба
6.2	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөд зориулан аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа, аймгийн ажлын талаар мэдээлэл бэлтгэн хүргүүлэх	Улирал бүр	Ажлын алба

6.3	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх	Тухай бүр	Ажлын алба
6.4	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, Хурлын үйл ажиллагааг цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлуулах	Тухай бүр	Ажлын алба
6.5	Хурал, Төлөөлөгчдийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор орон нутгийн телевизээр “Төлөөлөгчийн цаг” нэвтрүүлэг явуулах	Сар бүр	Ажлын алба
6.6	Хурлын нэрэмжит олон нийтийг хамарсан арга хэмжээ 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Жилдээ	Ажлын алба
7. Сургалт семинар			
7.1	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөд “Шилэн дансны тухай хууль”-аар мэдээлэл семинар өгөх	1-р улирал	Ажлын алба, аймгийн ЗДТГ-ын СТСХ
7.2	Сэлэнгэ аймагт цахилгаан дамжуулах, түгээх ажил үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөд мэдээлэл өгөх	1-р улирал	“Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, Ажлын алба
7.3	Аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчдөд “Хөгжлийн бодлогыг төлөвлөхөд Ногоон хөгжлийн асуудлыг тусгах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулах	Жилдээ	Ажлын алба, БОАЖГ
7.4	БИНХ-уудаар “Байгаль хамгаалах хуулийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Жилдээ	Ажлын алба, Хууль зүйн хэлтэс
7.5	Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын удирдах ажилтнуудын уулзалт зөвлөлгөөнд оролцох	Улиралд	
7.6	Хурлын Тэргүүлэгчид зарим аймгуудад туршлага судлах	3-р улиралд	Тэргүүлэгчид
7.7	Ерөө, Хүдэр сумдын Хурлын ажлын туршлагыг судлах, уулзалт семинарыг сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын дунд зохион байгуулна	3-р улиралд	Ажлын алба

7.8	Хурлын ажлын албаны ажилтнуудыг хөгжүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор тодорхой сэдвээр сар бүр сургалт зохион явуулах	Сар бүр	Ажлын алба
-----	---	---------	------------

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21-ний өдөр Дугаар 12

Сүхбаатар

**Нэрэмжит болгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 6.2, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ерөнхий боловсролын сургуулийг тус сумын уугуул, Монгол улсын төрийн соёрхолт, Хөдөө аж ахуйн ухааны доктор, дэд профессор Раагийн Жавзмаагийн нэрэмжит болгосугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21-ний өдөр

Дугаар 13

Сүхбаатар

**Лувсаншаравын Жалхарыг Монгол улсын  
Гавьяат механикжуулагч цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарт тасралтгүй идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Баянгол сумын “Газар баян” нөхөрлөлийн захирал Лувсаншаравын Жалхарыг Монгол улсын Гавьяат механикжуулагч цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21-ны өдөр Дугаар 15

Сүхбаатар

**Сэлэнгэ аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын  
ажлын тайланг зөвшөөрөх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, “Амьтны тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн 2014 оны төсөвт тусган аймгийн Засаг даргын захиалгаар Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Монголын анчдын нийгэмлэг” Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн Сэлэнгэ аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлын тайланг зөвшөөрсүгэй.

Хоёр.Уг тайланг үндэслэн боловсруулсан “Сэлэнгэ аймгийн агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө”-г Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 11-ны өдөр Дугаар 19

Сүхбаатар

**Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Сайхан сумаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.2014 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 148 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтад Сайхан суманд арчилгааны огтлолоор 200 шоо метр, цэвэрлэгээний огтлолоор 800 шоо метр шинэс модыг хэрэглээний зориулалтаар Сант сумын нутгаас бэлтгэхээр нэмж оруулсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 12-ны өдөр Дугаар 25

Сүхбаатар

### **Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын уран сайхны бодлого чиглэл, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар “Сэлэнгийн долгио чуулга”-ын дарга Д.Уранбилэгийн мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга” нь аймгийн ард иргэдэд соёл урлагийн чиглэлээр үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулж зах зээлийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн уран бүтээлийн төрөл хэлбэрээ олшруулж дуулалт болон драмын, мөн хүүхдийн жүжгүүдийг тайзнаа тавьж олны хүртээл болгон ажиллаж байна.

2014 онд хөдөөгийн ард иргэдэд соёлын үйлчилгээг үзүүлж сум орон нутагт 2 бүтээлээр 16 удаагийн тоглолт хийж нийт 2000 гаруй үзэгчдэд үйлчилжээ. Үүний зэрэгцээ байгууллагын уран бүтээлчдийн хөрвөх чадварыг сайжруулан “Гэгээн Муза” олон улсын урлагийн наадамд амжилттай оролцуулж “Гоолингоо” дуулалт жүжгээр оролцон “Шилдэг зохиолч”, “Шилдэг эрэгтэй туслах дүр”-ийн шагнал, мөн мэргэжлийн дуулаачдын “Алтан намар” улсын уралдаанд тусгай байрын шагналыг хүртэж аймаг орон нутгаа улс болон олон улсын хэмжээнд сурталчилсан байна.

Гэвч ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын төсөвт уран бүтээл туурвихад зарцуулах зардал, мөнгө дутмаг, соёл урлагийн мэргэжлийн боловсон хүчин, соёл урлагийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах, эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудал хангалтгүй байгааг тэмдэглээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д ДААЛГАХ нь:

1.Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ыг шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, техник, тоног төхөөрөмж, хөгжим зэмсэгийн шинэчлэлт хийхэд шаардлагатай төсөв зардлыг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт шат дараатайгаар тусгах болон холбогдох эрх



бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх замаар уран бүтээл туурвих нөхцөл боломжоор хангах.

2.Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын одоогийн ажиллаж байгаа бүтэц бүрэлдэхүүнд тулгуурлан өнөөгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөрвөх чадвар сайтай Хөгжимт жүжгийн театр болгох асуудлыг нухацтай судлан холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.

Хоёр.Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын дарга /Д.Уранбилэг/-д ДААЛГАХ нь:

1.Уран бүтээлчдийн мэргэжил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч уран бүтээлчдийг эчнээ болон давтан сургалтанд хамруулах замаар тэдний тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх.

2.Уран бүтээлийн төрөл хэлбэрийг шинэчлэн өргөжүүлэх, урын санг баяжуулан мэргэжлийн түвшинд уран бүтээл туурвих, хөдөөгийн иргэд малчдад явуулын үйлчилгээгээр хүргэх, уран бүтээлээ сурталчилах.

3.Иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг сайжруулан тохижилт үйлчилгээний чанарыг дээшлүүлэх.

4.Сумдын соёлын байгууллагуудад мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 12-ны өдөр Дугаар 26

Сүхбаатар

**Нэрэмжит болгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 108 тоот тогтоолоор баталсан “Гудамж талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах, нэрэмжит арга хэмжээ, шагнал бий болгох журам”-ын 3.1, 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийг Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын уугуул, академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яамны сайд асан Базарын Дэмбэрэлийн нэрэмжит болгосугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 12-ны өдөр Дугаар 28

Сүхбаатар

**Пунцагхоролын Гончигжавыг Монгол Улсын  
Гавьяат тээвэрчин цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Авто тээврийн салбарт олон жил тасралтгүй ажиллаж эзэмшсэн техниктээ үйлчилгээ тохиргоог чанартай хийж эдийн засгийн хэмнэлт гарган, аймаг, улсын аваргаар удаа дараа шалгарч байсан ажлын амжилтыг нь үнэлж Алтанбулаг сумын ахмад Пунцагхоролын Гончигжавыг Монгол улсын Гавьяат тээвэрчин цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 01-ны өдөр Дугаар 32

Сүхбаатар

**Ой тэмдэглэх тухай**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Мандал сумын Хэрх тосгоны Ерөнхий боловсролын сургууль байгуулагдсаны 80 жилийн ойг 2015 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж байгууллага, хамт олныхоо идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тус тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Ч.Одгэрэл/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 01-ны өдөр Дугаар 33

Сүхбаатар

**Ой тэмдэглэх тухай**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Алтанбулыг сумын Эрүүл мэндийн төв байгуулагдсаны 90 жилийн ойг 2015 оны 08 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2. Ойгоо угтаж байгууллага, хамт олныхоо идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Ц.Эрдэнэтүяа/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 01-ны өдөр Дугаар 38

Сүхбаатар

**Пэрэнлэйн Цэрмаг Монгол улсын  
Гавьяат багш цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Боловсролын салбарт тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж, эх орныхоо ирээдүй болсон хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх нэр хүндтэй, ариун үйлсэд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулсныг нь үнэлж Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгч Пэрэнлэйн Цэрмаг Монгол улсын Гавьяат багш цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 01-ны өдөр Дугаар 39

Сүхбаатар

**Лүүлүүгийн Ганболдыг Монгол улсын  
Гавьяат механикжуулагч цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын газар тариалангийн салбарыг хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах үйлсэд олон жил тасралтгүй ажиллаж байгаа Сайхан сумын “Ургацын Ундраа” ХХК-ийн захирал Лүүлүүгийн Ганболдыг Монгол улсын Гавьяат механикжуулагч цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 41

Сүхбаатар

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Багшийн хөгжил" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, нэгдсэн удирдлагаар ханган биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 22-ны  
өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралт

## **“БАГШИЙН ХӨГЖИЛ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Сэлэнгэ аймгийн багш нарын ажлын нөхцөл, эрүүл мэнд, нийгмийн байдал**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 35 сургуульд 983 үндсэн багш, сургуулийн өмнөх боловсролын 35 байгууллагад 244 багш, нийт 1227 багш ажиллаж байна.

Багш нарын 62.0 хувийг залуу багш /20-39 насны/, 25.2 хувийг дунд насны /40-49 насны/ багш, 12.8 хувийг ахмад багш /50 түүнээс дээш насны/ эзэлж байгаа бөгөөд боловсролын зэргийн хувьд магистр 7,7 хувь, бакалавр 67.7 хувь, дипломын 21.0 хувь, бусад 3,6 хувьтай, мэргэжлийн зэргийн хувьд 0.49 хувь нь зөвлөх, 10.6 хувь нь тэргүүлэх, 33.8 хувь нь заах аргач зэрэгтэй багш нар байна.

Нийт багш нарын дийлэнх буюу 62 хувийг залуу багш нар эзэлж байгаа бөгөөд тэдний нийгмийн асуудлыг хөндсөн бодлого зайлшгүй хэрэгтэй юм.

Багш нарын 87.4 хувь нь өөрийн эзэмшлийн, 13.5 хувь нь түрээсийн байранд амьдарч байгаа ба 29.7 хувь нь нийтийн орон сууцанд, 26.2 хувь нь бие даасан тохилог сууцанд, 27.5 хувь нь хашаа байшинд, 2.4 хувь нь гэрт амьдарч байна.

Эрүүл мэндийн судалгаанд хамрагдсан багш нарын дундаж нас 36, эрэгтэй 19.6, эмэгтэй 80.4 хувийг эзэлж байгаа бөгөөд дундаж жин 63.2, өндөр 153.1, биеийн жингийн индекс 24.3 хувьтай байна. Өвчлөлийн байдлыг судалж үзэхэд:

- Шүд-40.9%
- Нүд -29.0%
- Ялгаруулах эрхтний-27.0%
- Харшлын гаралтай- 20.9%
- Даралт ихтэй -17.0%
- Мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй- 12.5%
- Зүрх судасны өвчлөл-11.0%
- Мэдрэлийн системийн- 9.1%
- Хоол боловсруулах эрхтэн- 8.3%
- Даралт хэт багатай-7.7%
- Элэг-6.4%
- Үржлийн эрхтний-6.1%
- АЗЭ-ийн өвчлөл-1.9%
- Арьсны -1.6%
- Хавдар-1.4%

Сүүлийн 2 жилд 23.2 хувь нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол 22.4 хувь нь гэрээр, 3.5 хувь нь сувилалд эмчлүүлсэн, 18.5 хувь нь огт эмчилгээ

хийлгээгүй байна.

Сүүлийн жилүүдэд багш нарт дулаан хангамжийн дутагдал, ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөл ихэсч, ажлаа хийж байгаад нас барсан тохиолдол нэмэгдэж байна.

Ажлын байрны нөхцлийг 41.1 хувь нь хангалтгүй гэж үзсэн байгаа бөгөөд техник тоног төхөөрөмж хангалтгүй байна гэж 56.9 хувь нь, сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй байна гэж 65.1 хувь нь, 36.6 хувь нь дулаан хангамж дутагдалтай байна гэж үзжээ.

Амьжиргааны хувьд судалгаанд хамрагдсан нийт багш нарын 5.4 хувь нь хүнсний ногоо тариалдаг, 9.9 хувь нь мал аж ахуй эрхэлдэг, 81.1 хувь нь ямар нэг аж ахуй эрхэлдэггүй байна. 35.0 хувьд нь өрхөд өөр ажил эрхэлдэг гишүүн байхгүй байгаа бол судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн багш нарын 98 хувь нь, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 90.9 хувь нь банкинд ямар нэг зээлтэй гэж хариулсан байна.

### **Хоёр. Хөтөлбөрийн үндэслэл**

Монгол улсын Боловсролын тухай хууль, БСШУЯ, Монголын боловсролын байгууллагыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө 2008-2021 он, Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 316 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, БСШУ-ы сайдын 2012 оны А/136 дугаар тушаалаар батлагдсан “Багшийн хөгжил” хөтөлбөр, “Монгол улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” /2012-2016/ нь энэхүү хөтөлбөрийн гол эх сурвалж болно.

БСШУ-ы сайдын 2012 оны 11 дүгээр сарын 22-ны А/136 тоот тушаалаар батлагдсан “Багшийн хөгжил” хөтөлбөр нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багш төлөвшүүлэх, тэргүүн туршлагыг түгээх, нэр хүндийг өсгөхөд чиглэсэн бол Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх “Багшийн хөгжил” дэд хөтөлбөр нь багш нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах, тэдний өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийг нь дэмжих, орон сууцны асуудлыг шийдвэрлэх, багшийн үнэлэмж дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэгдэнэ.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго**

“Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийн зорилго нь Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа багш нарын мэргэжил үнэлэмжийг дээшлүүлж, тасралтгүй хөгжлийг хангах, ажлын байрны нөхцөл, эрүүл мэнд, орон сууцны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, нийгмийн

хамгааллыг сайжруулахад оршино.

### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилт**

Зорилт 1.Багшийн мэргэжил, үнэлэмжийг дээшлүүлэх, тасралтгүй хөгжлийг хангах

Зорилт 2.Багш нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах, Багш нарын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

Зорилт 3.Багш нарын орон сууцны нөхцлийг сайжруулах, дэмжих

Зорилт 4.Багш нарын өрхийн амьжиргааг дэмжих

### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

Хөтөлбөрийг 2015-2020 онд хэрэгжүүлж, цаашид боловсролын салбарт багшийн нийгмийн хамгааллыг сайжруулахад чиг баримжаа болгоно.

### **Зургаа. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

Зорилт 1 хүрээнд: Багшийн мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжлийг хангах

1.1.Үндэсний үндсэн болон төрөлжсөн, ажлын байран дээрх сургалтуудад хамруулж, багшийн мэдлэг чадварыг дээшлүүлэх

1.2. Мэдээлэл харилцааны технологийг ашиглан зайны сургалт явуулах, мэдээ, мэдээллийг түгээж, багш бүрийн мэргэжил дээшлүүлэх

1.3. “Цахим сургууль-цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1.4. Ур чадварын уралдааныг зохион байгуулж, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, технологийн сан”, “Сайн хичээлийн сан” бүрдүүлэх

1.5. Шилдэг илтгэлийн уралдаан, төрөлжсөн хичээлийн олимпиадуудыг үе шаттай зохион байгуулах

1.6. Багш бүрийг судалгаа шинжилгээний арга зүйд сургах ажлыг зохион байгуулах

1.7. Тэргүүний арга ажиллагаатай сургууль, цэцэрлэг, захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч, мэргэжлийн багш, анги удирдсан багш нарын шинэ санаачилга, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сайн туршлагын сан бүрдүүлэх

1.8. Шилдэг, тэргүүний багш нарын ажил хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж төр, засгийн болон аймаг, орон нутгийн шагнал урамшуулалд хамруулах

1.9. Багш, удирдах ажилтны тэргүүн туршлага, цахим хичээлийг аймгийн сайтад байршуулах, төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран нэвтрүүлэг ярилцлага хийх

1.10. Багш, сурагчдыг дотоод, гадаадын сургууль, цэцэрлэгүүдэд харилцан туршлага судлуулах ажлыг тусгай удирдамж боловсруулан хэрэгжүүлэх

Зорилт 2 хүрээнд: Багш нарын ажлын байрны нөхцөлийг сайжруулж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх

1.1. Сургалтын техник тоног төхөөрөмжийн хүрэлцээг сайжруулах

1.2. Багш нарын сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, нийлүүлэх зардлыг шийдвэрлүүлэх

1.3. Багш нарыг дүрэмт хувцастай болгох

1.4. Ажлын байрны дулаан хангамжийг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх

1.5. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношлогоонд тогтмол хамруулах

1.6. Байгууллага бүр эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны цагтай болж, ажлын байран дээрээ эрүүлжих үйл ажиллагааг тогтмолжуулах

1.7. Улирлын амралтаар эмчилгээ, сувилгаа хийлгэхэд нь байгууллагын зүгээс боломжтой нөхцөлд дэмжлэг үзүүлэх,

1.8. Аймгийн төвд “Багшийн сургалт хөгжлийн төв”, “Багш нарын амралт сувилалын газар” байгуулах ажлыг эхлүүлэх

Зорилт 3 хүрээнд: Багш нарын орон сууцны нөхцлийг сайжруулах дэмжих

1.1. Сумдад шаардлагатай мэргэжлээр шинээр ажилд орсон багш нарыг орон байраар хангах, сумдад багш нарын томилолтын байртай болох

1.2. Багш нарыг орон сууцны хөтөлбөрт хамруулах боломжийг нэмэгдүүлэх, тэднийг хувийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх

Зорилт 4 хүрээнд: Багш нарын өрхийн амьжиргааг дэмжих

1.1. Төмс, хүнсний ногоо тариалах, борлуулах, туслах аж ахуй эрхлэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

1.2. Өрхийн амьжиргааг дээшлүүлэх төсөл, хөтөлбөр, сургалтанд хамруулах

1.3. Зуны амралтаар сурагчдын хамт “Хөдөлмөр амралтын зуслан”-д ажиллах боломжийг бүрдүүлэх

### **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт**

“Багшийн хөгжил” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

7.1 Улсын төсөв

7.2 Орон нутгийн төсөв

7.3 Гадаад, дотоод байгууллагын хандив тусламж

7.4 Бусад

## Найм. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Засгийн Газрын баталсан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийн хүрээнд сургууль, цэцэрлэг бүр байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлнэ.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймаг, сумын Засаг дарга нар дэмжлэг үзүүлж аймгийн Боловсрол соёлын газар хариуцан зохион байгуулж ажиллана.

8.4. Хөтөлбөрийн явц, хүрсэн үр дүнгийн талаар аймгийн Засаг дарга, Боловсрол соёлын газар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

### Ес. Гарах үр дүн

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүн гарна. Үүнд:

- Багшийн мэргэжлийг дээшлүүлж, тасралтгүй хөгжлийг хангаснаар багш нарын мэргэжил, ур чадвар дээшилнэ
- Сайн хичээлийн сан бүрдүүлснээр багш нар бие биеэсээ суралцах, туршлага судлах боломж бүрдэнэ
- ЕБ-ын сургуулиуд физик, хими, биологи, технологи, хөгжмийн хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангагдсанаар тухайн хичээлийн чанар, үр дүн дээшилнэ
- Багш нарын сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг шийдвэрлүүлснээр сургалтын хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж дээшилнэ.
- Багш нар дүрэмт хувцастай болсноор багш, сурагчдын харилцаанд эерэг өөрчлөлт гарч, байгууллагын соёл бүрдэнэ.
- Багш нарыг өрхийн орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтанд хамруулснаар өрхийн орлогын эх үүсвэр бий болно.
- Хөдөлмөр амралтын зуслан байгуулж, багш нарыг ажиллуулснаар багш нарт зуны амралтаараа амрах, ажиллах боломж бүрдэнэ
- Багш нарыг эрүүл мэндийн үзлэг, сувилалд хамрагдах боломж олгосноор өвчлөл буурна
- “Багшийн хөгжлийн төв”, “Багш нарын амралт сувилал, сургалтын төв” байгуулах ажил эхэлнэ.
- Багш нар шинээр орон сууцтай болж, орон сууцны нөхцөлөө сайжруулснаар ажил хөдөлмөртөө ахиц гаргах боломж бүрдэнэ.

## Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

### Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур:

#### 1 дүгээр зорилтын хүрээнд:

- Үндэсний үндсэн болон төрөлжсөн, ажлын байран дээрх сургалтад хамрагдаж, мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн багшийн тоо нэмэгдсэн байх
- Мэдээлэл харилцааны технологийг ашиглан зайны сургалт явуулах, мэдээ, мэдээллийг түгээж, багшийн мэргэжил дээшлүүлэх боломж нөхцөл бүрдсэн байх
- “Цахим сургууль-цахим сургалт” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөдөөгийн сум, сургууль, цэцэрлэг бүр өндөр хурдны интернэт ашиглан мэдээлэл, харилцааны технологийг ашиглах боломж бүрдсэн байх
- Ур чадварын уралдааныг зохион байгуулж, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, технологийн сан”, “Сайн хичээлийн сан”-г мэргэжил бүрээр бүрдүүлсэн байх
- Шилдэг илтгэлийн уралдаан, төрөлжсөн хичээлийн олимпиадуудыг зохион байгуулж, багшлах арга зүйд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, багшийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, боловсролын шинэчлэлийг дэмжих багшийн хөгжлийн болон, сургалтын практикт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн, тэргүүн туршлагыг судлах, бусдад түгээх боломжийг бүрдүүлэх, багшийг судалгаа шинжилгээний арга зүйд сургах ажлыг тогтмол зохион байгуулж, ахиц гарсан байх
- Жил бүр багш, сурагчдыг гадаад, дотоодод харилцан туршлага судлуулах ажил тогтмолжсон байх

#### 2 дугаар зорилтын хүрээнд:

- Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж өмнөх онуудынхаас нэмэгдсэн байх
- Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, нийлүүлэх зардлыг нэмэгдүүлж, шийдвэрлэсэн байх
- ЕБС, цэцэрлэгийн багш нар дүрэмт хувцастай болж, журмын дагуу өмсөж хэвшсэн байх
- Ажлын байрны дулаан хангамж, тохижилт дээшилсэн байх
- Сургууль, цэцэрлэг бүр багш нарыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулдаг болсон байх
- Улирлын амралтаар эмчилгээ, сувилгаа хийлгэхэд нь чөлөө олгодог, дэмжлэг, туслалцаа үзүүлдэг болсон байх
- “Багшийн хөгжлийн ордон”, “Багш нарын амралт сувилал, сургалтын төв” байгуулах ажил эхэлсэн байх

3 дугаар зорилтын хүрээнд:

- Сумдад шаардлагатай мэргэжлээр шинээр ажилд орсон багш нарыг орон байраар хангасан тоо нэмэгдсэн байх
- Орон сууцны хөтөлбөрт багш нарыг хамруулах тэднийг хувийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлсэн тоо нэмэгдсэн байх

4 дүгээр зорилтын хүрээнд:

- Хувьдаа туслах аж ахуй эрхлэн өрхийн орлогоо нэмэгдүүлдэг багшийн тоо нэмэгдсэн байх
- Багш нарыг өрхийн орлогыг дээшлүүлэх төсөл хөтөлбөр, сургалтанд хамруулсан байх
- Зуны амралтаар сурагчдын хамт “Хөдөлмөр амралтын зуслан”-д ажиллах боломжтой болсон байх

оОо

---



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 42

Сүхбаатар

**Журам батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.”Сэлэнгэ аймагт сум, байгууллагын хэмжээнд тэгш ой тэмдэглэхэд зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 22-ны  
өдрийн 42 дугаар тогтоолын хавсралт

## **СЭЛЭНГЭ АЙМАГТ СУМ, БАЙГУУЛЛАГЫН ТЭГШ ОЙ ТЭМДЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Сэлэнгэ аймагт сум, орон нутгийн төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, байгууллагуудад 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай түүхэн тэгш ой тэмдэглэх зөвшөөрөл олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### **Хоёр.Ой тэмдэглэх зөвшөөрөл хүсэх**

2.1.Орон нутгийн төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын дарга /захирал/ нь тухайн байгууллага байгуулагдсаны тэгш ойг тэмдэглэх хүсэлтээ сумын Засаг даргад уламжилна.

2.2.Сумын Засаг дарга хүсэлтийг судлан үзэж өөрийн саналын хамт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан хэлэлцүүлнэ.

2.3.Сум байгуулагдсаны тэгш ойг тэмдэглэх саналыг сумын Засаг дарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанд оруулан хэлэлцүүлнэ.

2.4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд сум, байгууллагын тэгш ой тэмдэглэх хүсэлтийг дэмжих эсэх шийдвэр гаргана.

2.5.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид сум, байгууллагын тэгш ой тэмдэглэхийг дэмжвэл сумын Засаг дарга энэ журмын 2.6-д заасан материалыг бүрдүүлэн 06-аас доошгүй сарын өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

2.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ой тэмдэглэх хүсэлт ирүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

а/.байгууллага, хамт олноос ой тэмдэглэх тухай санал хүсэлтээ илэрхийлж сумын Засаг даргад хандсан албан бичиг

б/.байгууллагын түүхийн талаар товч мэдээлэл, ойн хүрээнд хийгдэх ажлын чиглэлийн талаарх мэдээлэл

в/.ой тэмдэглэх тухай асуудлыг хэлэлцсэн тухайн хамт олны хуралдааны шийдвэр, тэмдэглэл

г/.умын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс сум байгууллагын тэгш ой тэмдэглэх саналыг дэмжиж аймгийн ИТХ-д уламжилсан шийдвэр, хуралдааны тэмдэглэл болон сумын Засаг даргын санал

2.7.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага тэгш ой тэмдэглэх хүсэлтээ аймгийн Засаг даргад ирүүлнэ.

2.8.Аймгийн Засаг дарга хүсэлтийг судлан үзэж энэ журмын 2.6 дахь

заалтын “а”, “б”, “в”-д заасан материалыг бүрдүүлэн өөрийн саналын хамт 06-аас доошгүй сарын өмнө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

2.9.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба аймаг, сумын Засаг даргаас ирүүлсэн материалыг судлан үзэж 2.6-д заасан материалын бүрдлийг хангаагүй тохиолдолд хүсэлтийг буцаана.

### **Гурав.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох**

3.1.Сум, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцэж тухай сум байгууллагын тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх он, сарыг тодорхойлон зөвшөөрөл олгож шийдвэр гаргана.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 44

Сүхбаатар

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах  
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 14 тоот тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 22-ны  
өдрийн 44 дүгээр тогтоолын хавсралт

АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Орлогч дарга: -Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт  
хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан  
ажилтан

Гишүүд:-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга

-Сум дундын 20 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч

-Аймгийн Прокурор

-Аймгийн Цагдаагийн газрын дарга

-Аймгийн Тагнуулын газрын дарга

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Аймгийн Онцгой байдлын газрын дарга

-Хилийн бүрэн эрхт төлөөлөгч

-Аймгийн боловсролын газрын дарга

-Аймгийн Байгаль орчны газрын дарга

-Хилийн 0101-р ангийн захирагч

-Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга

оОо



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 48

Сүхбаатар

**Мэргэжлийн комисс томилох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4-ийн 3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралын 2-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баянгол сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал боловсруулах мэргэжлийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

1.Мэргэжлийн комиссын дарга- С.Бүрэнбат /аймгийн Засаг дарга

2.Нарийн бичгийн дарга- Д.Батдэлгэр /ГХБХБГ-ын дарга/

Гишүүдэд:

1.Б.Энхбат- Баянгол сумын Засаг дарга

2.Г.Саранцэцэг- Баянгол сумын газрын даамал

3.Д.Болортуяа- Баянгол сумын 3-р багийн Засаг дарга

4.М.Ганбаяр- Баянгол сумын БОУБайцаагч

5.М.Дэлгэрням- Баянгол сумын иргэний төлөөлөл

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалт хийх журмын дагуу санал боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг мэргэжлийн комиссын дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 49

Сүхбаатар

**Мэргэжлийн комисс томилох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4-ийн 3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралын 2-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөө сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал боловсруулах мэргэжлийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

1.Мэргэжлийн комиссын дарга- С.Бүрэнбат /аймгийн Засаг дарга

2.Нарийн бичгийн дарга - Д.Батдэлгэр /ГХБХБГ-ын дарга/

Гишүүдэд:

1.Б.Сэргэлэн- Ерөө сумын Засаг дарга

2.Э.Ариунбат - Ерөө сумын газрын даамал

3.Л.Болормаа - Ерөө сумын 2-р багийн Засаг дарга

4.Л.Айболд- Ерөө сумын БОУБайцаагч

5.Б.Энхтуяа- Ерөө сумын иргэний төлөөлөл

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалт хийх журмын дагуу санал боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг мэргэжлийн комиссын дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 04 сарын 22-ны өдөр Дугаар 50

Сүхбаатар

**Орон нутгийн өмчит компаниуд, үйлдвэрийн газрын  
2014 оны үйл ажиллагааны тухай**

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Гавшгай ус”, “Цант Орхон”, “Урсгал ус” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд, “Сэлэнгэ Энерго” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2014 оны үйл ажиллагааны тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ НЬ:

Орон нутгийн өмчит компаниуд, үйлдвэрийн газар нь нөөц бололцоогоо ашиглан техник тоног төхөөрөмжөө шинэчлэх, шугам сүлжээний засвар үйлчилгээг цаг тухайд нь тогтмол хийж гүйцэтгэж, ажилтан албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг сайжруулах талаар санаачилгатай ажиллаж хүлээсэн үүргээ доголдолгүй хэрэгжүүлэн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, ард иргэдийн ахуй амьдралын анхдагч чухал хэрэгцээт үйлчилгээг хэвийн хэмжээнд гүйцэтгэж ирсэн байна.

2014 оны санхүүгийн тайлан балансаар “Урсгал ус” компани 782,5 сая төгрөгийн авлага, 605,6 сая төгрөгийн өглөгтэй, 20,4 сая төгрөгийн ашигтай, “Цант Орхон” компани 14,8 сая төгрөгийн авлага, 7,3 сая төгрөгийн өглөгтэй, 30,1 сая төгрөгийн ашигтай ажилласан бол “Гавшгай ус” компани 683,8 төгрөгийн авлага, 914,8 сая төгрөгийн өглөгтэй, 245,8 сая төгрөгийн алдагдалтай, “Сэлэнгэ Энерго” үйлдвэрийн газар 535,8 сая төгрөгийн авлага, 1887,8 сая төгрөгийн өглөгтэй, 459,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гэвч эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүгнэлт хийж үзвэл үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгон сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх, өр авлагыг барагдуулах зэрэг олон асуудлуудыг судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал нарт ДААЛГАХ нь:

1. Байгууллагынхаа бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох,

үйл ажиллагааны менежментээ сайжруулан зардлаа хэмнэж, өр авлагаа бууруулах талаар идэвх санаачилга гарган ажиллах,

2.Иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ бүтээгдэхүүний нэр төрлийг олшируулж, чанар хүртээмжийг дээшлүүлэн хэрэглэгчийн тоог өсгөх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх,

3.Цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад усны тоолуур суурилуулж бодит хэрэглээгээр өр төлбөрийг тооцох, усны алдагдлыг бууруулах,

Хоёр. Аймаг, сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1.Орон нутгийн өмчит компаниуд, үйлдвэрийн газартай холбоотой олон жил хуримтлагдсан өр авлагыг барагдуулах арга замыг судлан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх,

2.Орон нутгийн өмчит компаниуд, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж, их засварын зардлыг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт ээлж дараатай тусган шийдвэрлэх,

3.Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх санал боловсруулж Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх,

4."Гавшгай ус" орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар эдийн засгийн үнэлгээ шинжилгээ хийлгэж, тус компанийн төсвийн алдагдлыг бууруулж ашигтай ажиллуулах арга замыг судлан тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

ДАРГА Ж.САНЖЖАВ





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 07-ны өдөр Дугаар 52

Сүхбаатар

**Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ажиллах  
Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтоох тухай**

Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ажиллах Олон нийтийн цагдаагийн ажилтны тоог доор дурьдсанаар тогтоосугай. Үүнд:

1.Баруунбүрэн сум	- 1
2.Баянгол сум	- 1
3.Ерөө сум	- 1
4.Мандал сум	- 5
5.Сайхан сум	- 2
6.Сүхбаатар сум	- 5
7.Цагааннуур сум	- 1
Нийт	<b>16</b>

Хоёр.Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гаргасан иргэдийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж олон нийтийн цагдаагийн ажилтнаар ажиллуулах боломжтой гэж үзсэн иргэнийг сумдын Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн томилж, гэрээ байгуулан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллуулахыг аймгийн цагдаагийн газрын дарга /Цагдаагийн хурандаа Д.Энхбаяр/-д даалгасугай.

Гурав.Олон нийтийн цагдаагийн ажилтны хувцас, таних тэмдэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, урамшууллын зардлыг томилогдсон өдрөөс нь эхлэн батлагдсан төсөвт нь багтаан санхүүжүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, төсвийн шууд захирагч /Э.Оюунболд/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 07-ны өдөр Дугаар 53

Сүхбаатар

**Балжиннямын Баттөрийг Монгол улсын  
Гавьяат жүжигчин цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Соёл урлагийн салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа Сэлэнгэ аймгийн уугуул, Соёл урлагийн их сургуулийн багш Балжиннямын Баттөрийг Монгол улсын Гавьяат жүжигчин цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 07-ны өдөр Дугаар 54

Сүхбаатар

**Нумчингийн Давдаг Монгол улсын  
Гавьяат багш цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Боловсролын салбарт тасралтгүй 40 гаруй жил ажиллаж, эх орныхоо ирээдүй, өсвөр үеийнхнийг сурган хүмүүжүүлэх нэр хүндтэй, ариун үйлсэд олон жилийн хүч хөдөлмөрөө зориулсныг нь үнэлж Ерөө сумын ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн ахмад багш Нумчингийн Давдаг Монгол улсын Гавьяат багш цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 21-ны өдөр Дугаар 57

Сүхбаатар

**Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр  
өргөмжлөх тухай**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 81 дүгээр тогтоолоор баталсан Сэлэнгэ аймгийн шагналын журмын 2.1.1, 4.1.”а”-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Оросын Холбооны улсын Буриад улс Сэлэнгэ аймаг хоорондын уламжлалт найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Оросын Холбооны улсын Буриад улсын Ерөнхийлөгч Вячеслав Владимирович Наговицыныг Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилсүгэй.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 26-ны өдөр Дугаар 58

Сүхбаатар

**Эрдэмтэн зохиолч Бямбын Ринченгийн 110 жилийн ойг  
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монголын төдийгүй дэлхийн хэмжээнд бүтээл туурвилаараа алдаршиж, хэл соёл, урлаг, утга зохиолыг хөгжүүлэхэд гарамгай амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн уугуул, их эрдэмтэн, билгүүн номч Бямбын Ринчений мэлмий гийсний 110 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Их эрдэмтэн, билгүүн номч Бямбын Ринчений мэлмий гийсний 110 жилийн ойг 2015 оны 11 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй баталсугай. Үүнд:

Дарга:

Н.Батдорж - Аймгийн Засаг даргын орлогч

Орлогч дарга:

Ж.Батсайхан- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Загдгочоо- Аймгийн Боловсрол соёлын газрын дарга

Н.Шинэчимэг- Аймгийн Нийтийн номын сангийн эрхлэгч

Д.Сундуй- Алтанбулаг сумын Засаг дарга

Н.Сүхдорж- Зохиолч, яруу найрагч

Ө.Бавуу - Эрдэмтэн, зохиолч

Н.Пүрэвдагва- Зохиолч, орчуулагч

Б.Эрдэнэ-Очир- Алтанбулаг сумын ЕБС-ийн захирал

Нарийн бичгийн дарга:

Ц.Отгонтуяа- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

3. Монгол хэл, түүх соёлоо хамгаалан хөгжүүлэхийн төлөө тууштай тэмцэгч Б.Ринчений гэгээн дурсгалын төрөлх нутаг орондоо мөнхжүүлэх тодорхой ажил арга хэмжээг төлөвлөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Батдорж/-д даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 59

Сүхбаатар

### Зохион байгуулах хороо байгуулах тухай

Монгол улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ардын хувьсгалын 94 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тус аймагт 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд тэмдэглэхээр тогтоосугай.

2.Ардын хувьсгалын 94 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах аймгийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Зохион байгуулах хорооны дарга

Н.Батдорж-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга Ө.Сувдаа -Аймгийн ЗДТГ-ын дарга

Гишүүд

С.Отгонжаргал-Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Ч.Даваадорж-Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга

Ч.Дэмбэрэлсайхан-Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Ж.Батсайхан-Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

А.Сарантуяа-Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Х.Даваахүү -Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Баттулга-Аймгийн Биеийн тамир спортын газрын дарга

Д.Энхбаяр-Аймгийн Цагдаагийн газрын дарга

Ш.Отгонбаяр-Аймгийн Татварын хэлтсийн дарга

Л.Энхтайван-20 дугаар Шүүхийн ерөнхий шүүгч

Г.Чагдар-Аймгийн Прокурор

3.Ардын хувьсгалын ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардлын төсвийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлуулахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 60

Сүхбаатар

### Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 1.1, “Амьтны тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 5.4.2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 267 тоот тогтоол “Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх” үндэсний хөтөлбөр, 2011 оны 114 тоот тогтоол “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 14.4 дэх заалт, ХХААХҮ, БОАЖ-ын сайдын хамтарсан А/104/252 дугаар тушаал “Загас” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан загас, загасан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор зориудын аргаар үржүүлэн өсгөвөрлөх, зах зээлд тогтмол нийлүүлэх замаар хүн амыг хүнсний уурагт бүтээгдэхүүнээр жигд хүртээмжтэй хангах зорилгоор “Загас” аймгийн дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, 2 дугаар хавсралтаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөг баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

3.“Загас” дэд хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын  
17-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралт 1

## **“ЗАГАС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

### **НЭГ: Ерөнхий зүйл**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 32-р тогтоолоор баталсан “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрт загасны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амын загас, загасан бүтээгдэхүүний хэрэглээг 2016 онд 25 хувиар нэмэгдүүлэхээр заасан билээ.

Манай оронд 14 овгийн 36 төрөл, 75 гаруй зүйлийн загас байдаг бөгөөд үүнээс 36 гаруй зүйл нь агнуурын ач холбогдолтой юм. Жилд манай улс 450 тонн загас агнан, 80 тонн загас экспортолж, 250-700 тн загас, загасан бүтээгдэхүүн импортоор авч, жилийн нийт нөөц 1000 тонн, нэг хүнд ногдох загасны хэрэглээний хэмжээ 0,2-0,3 орчим кг байгаа нь дэлхийн дунджаас ихээхэн доогуур байна.

Дэлхийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас (FAO) дэлхийн хүн амын загасны хэрэглээ нь 158 сая тонн болсон нь 50 жилийн өмнөхөөс хоёр дахин өсч, нэг хүнд дундажаар 17 кг ногдож, загас агнуурын хэмжээ төдийлөн нэмэгдээгүй, далайн загас үржүүлгээс хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн загасны хэмжээ ихэссэж, уургийн хэрэглээний 17 хувийг загасны махнаас авч байна.

Загасны маханд “Омега- 3” хэмээх тосны хүчил их хэмжээгээр агуулагддаг. Энэ хүчил нь зүрх судас, ясны эмгэг болон хорт хавдрын эсрэг үйлчилгээтэйг судлаачид тогтоожээ. Хүн өдөрт 35 гр загасны мах тогтмол хэрэглэхэд зүрхний шигдээсээр нас барах эрсдэл 50 хувиар буурдаг болохыг нотолжээ. Иймээс л далайн гаралтай хүнс их хэмжээгээр хэрэглэдэг Японы хүн ам дундаж наслалтын үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлдэг юм байна.

Мөн 2011 оны “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний дөрөвдүгээр судалгаагаар бага насны хүүхэд, төрөх насны эмэгтэйчүүдийн дунд “А”, “Д” аминдэм, уураг илчлэгийн дутагдалтайг тогтоосон нь хүн амын хүнсний хангамж, тэжээллэг байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байдаг.

Загасны мах нь төгс уураг, ханаагүй тосны хүчлийн агууламж ихтэй, хүний бие махбодид зайлшгүй шаардлагатай “А”, “Д”, “Е”-гийн бүлгийн аминдэм, төрөл бүрийн эрдэс бодис, нэн ялангуяа кальци, фосфор, йодиор баялаг, зөөлөн, шингэц сайтай, холестерингүй, байгалийн гаралтай бүтээгдэхүүн хүнсний үнэт түүхий эд, мөн хүүхдийн өсөлтөд тустай, тогтмол хэрэглэвэл хорт хавдраас сэргийлдэг.

Сэлэнгэ мөрний сав газарт манай улсын хүн амын 70 хувь, аж үйлдвэрийн 90 хувь нь төвлөрдгийн хувьд улс орны нийгэм, эдийн засгийн гол түшиц нутаг болдог.

Сэлэнгэ мөрөнд агнуурын ач холбогдолтой 15 зүйлийн загас



тэмдэглэгдсэн бөгөөд 2000 оноос загасыг өрхийн хэмжээнд утаж боловсруулан орон нутгийн хэмжээнд “брэнд” бүтээгдэхүүнтэй болоод байна. Мөн Хушаат болон Сүхбаатар суманд цөөрөм, голын цүнхээл хэсгийг хашин загасыг өсгөвөрлөн бойжуулж байгаа нь цаашид загас үржүүлгийн аж ахуйн суурь баазыг байгуулах боломжийг бүс нутагт олгож байна.

Иймээс Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Загас” дэд хөтөлбөрийн хүрээнд загас, загасан бүтээгдэхүүнээр хүн амыг тогтвортой хангах, агнуурын гоц ашигтай загасыг зориудын аргаар үржүүлэн байгалийн нөөцийг нэмэгдүүлэх, улмаар таваарын загасны аж ахуй хөгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

### **ХОЁР: Аймгийн загас, загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал**

2011 оны тооллогоор аймгийн хэмжээнд 619 гол горхи, 6 усан сан, 34 усалтын систем, 49 нуур цөөрөм, 8 үерийн хамгаалалтын даалан, 8 цэвэрлэх байгууламж, 247 булаг шанд, 30 рашаан , 5224 худаг байна. Энэхүү тооллого нь 4 жилд 1 удаа явуулдаг.

Манай аймагт 6 овгийн 12 төрлийн 26 гаруй зүйлийн загас бий үүнээс гучаад нь агнуурын загас бөгөөд Орхон, Сэлэнгэ мөрний ай сав газарт 26 зүйлийн загас байдгаас хоёр зүйл хадран, алгана, ердийн цурхай, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, гутаарь, улаан нүдэн, бух сугас, сибирь хилэм, тул, омуль зэрэг загас элбэг байдаг.

Олон голын бэлчир, Сэлэнгэ мөрөн, түүний цутгалан голуудаар тархсан нэг хилэм 3,08-11 кг түрс өгдөг 1945 оноос агналтыг бүрмөсөн хориглож дархан цаазтай болгосон.

2000 оноос загасыг өрхийн хэмжээнд утан боловсруулж, Орхон, Сэлэнгэ гол, Улаанбаатар хотоос түүхий эдээ бэлтгэн жилд 30 орчим тн загасыг хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж, аймгийн нэг хүнд 0,03 орчим кг загас, загасан бүтээгдэхүүн ногдож байгаа тоо харагддаг ч утсан загасны дийлэнх хувийг Улаанбаатар болон бусад аймаг, хотруу зөөвөрлөдөг.

Д/д	Бүтээгдэхүүний нэр төрөл	2013 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /тн/	Эхний үе шат 2015-2017;	Хоёр дахь үе шат 2018-2020;
1.	Загас	30 тн  /100 кг загас 40-50 ширхэг байдаг/	50 тн /Хушаат сумын “Ишгэнт нуур” ХХК, Сүхбаатар сумын “Бат дэм” ББН зэрэг аж ахуйн нэгжүүдийн загас үржүүлгийн газрыг өргөжүүлэх/	100 тн / Сүхбаатар, Орхон, Ерөө, Мандал, Баянгол, Хүдэр, Түшиг сумдад загас үржүүлгийн аж ахуй, боловсруулах үйлдвэр, цех, байгуулах/

Аймгийн хэмжээнд ахуйн хэрэгцээнд зориулан 5 000 ширхэг загас барих зөвшөөрлийг Байгаль орчны газраас жил бүр олгож байгаа боловч хууль бусаар загас агнах явдал буурахгүй байна.

Сүхбаатар, Орхон сумдын 2 аж ахуйн нэгж, 25 иргэд жилд 15 000 ширхэг загасыг утан боловсруулж, 195,0 сая төгрөгний борлуулалт хийж байна.

Боловсруулалт хийж буй иргэдийн ахуй нөхцөл ариун цэврийн шаардлага хангадаггүй, тодорхойлсон цэг, цех байхгүй нүүдлийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгааг цэгцлэх, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Аймгийн нутаг дэвсгэрт харъяалагдах нуур, голуудын загасны нөөцийг одоо болтол тогтоолгоогүй байгаа бөгөөд үржлийн үед нь олборлолт явуулж байгаа нь түүний байгалийн нөөцөд сөргөөр нөлөөлж байна. Иймд эхний ээлжид нуур, голуудын загасны зүйлийн бүрэлдэхүүн, тархалт байршил, экологийн төлөв байдлыг тогтоолгосны үндсэн дээр тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулан бүс нутгийн хэмжээнд эрчимжсэн загасны аж ахуй хөгжүүлэх боломжийг тогтоолгох шаардлагатай байна.

Манай аймгийн хэмжээнд НҮБ-ын “Даян Дэлхийн байгаль хамгаалах сан”-гийн санхүүжилтээр Хушаат сумын “Ишгэнт нуур” ХХК, Сүхбаатар сумын “Батдэм” ББН зэрэг аж ахуйн нэгжүүд агнуурын ач холбогдол бүхий нутгийн уугуул 4 төрлийн 4 зүйлийн загасыг өсгөн үржүүлж байгаа туршлага байна. Иймээс цаашид дээрх загасны аж ахуйн үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай нь уялдуулан холбож бүс нутгийн хэмжээнд таваарын загасны аж ахуйг хөгжүүлэх боломж байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулах шаардлага: Улс, аймгийн хэмжээнд цэнгэг усны загасны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор загасыг зориудын аргаар үржүүлэх бага оврын цехийг байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байгалийн болон шинээр байгуулсан нуур, цөөрөмд жараахай өсгөвөрлөн бойжуулж таваарын жинд хүргэх улмаар хүн амыг хүнсний уурагт бүтээгдэхүүнээр тогтмол хангах үүднээс загасыг үйлдвэрийн аргаар боловсруулж, жинхэнэ утгаар нь аймгийн “Брэнд” бүтээгдэхүүнтэй болох, загасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, нэг хүнд ноогдох хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулаа.

### **ГУРАВ: Дэд хөтөлбөрийн зорилго, тэргүүлэх зорилт**

Зорилго: Эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан загас, загасан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор зориудын аргаар үржүүлэн өсгөвөрлөх, зах зээлд тогтмол нийлүүлэх замаар хүн амыг хүнсний уурагт бүтээгдэхүүнээр жигд хүртээмжтэй хангахад ахиц гаргахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх тэргүүлэх зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

Нэгдүгээр тэргүүлэх зорилт:

Аймгийн загасны үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

### **Хоёрдугаар тэргүүлэх зорилт:**

Аймгийн гол мөрөн, цөөрөмд тархан амьдрах нэн ховор, ховор агнуурын ашигтай загасны тархалт, **төрөл, зүйл, нөөц**, байршил, үржлийн биологи, сүргийн бүтэц, идээш тэжээлийн судалгаа, нөөцийг тогтоож, загас өсгөн үржүүлэх аж ахуйг байгуулах, өргөжүүлэх, шинээр үүсгэн байгуулсан цөөрөмд загас үржүүлэх түүнийг хамгаалах.

#### **Гуравдугаар тэргүүлэх зорилт:**

Байгалийн загасны нөөц, үржүүлэгийн аж ахуйг түшиглэн загас боловсруулах жижиг цех байгуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар загас, загасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх мэдээлэл түгээж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх.

#### **Дөрөвдүгээр тэргүүлэх зорилт**

Аймгийн үржүүлгийн аж ахуй, загас боловсруулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг сурталчилах, борлуулалтанд дэмжлэг үзүүлэх.

### **ДӨРӨВ: Дэд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Нэгдүгээр тэргүүлэх зорилтын хүрээнд:

“Загас” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

Хууль бусаар загас барих, худалдах, боловсруулах ажлыг таслан зогсооход чиглэсэн эрхзүйн актуудын хэрэгжилтийг хангахад мэргэжлийн хяналтын болон хууль сахиулах байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах.

Хүн амын загас, загасан бүтээгдэхүүний хэрэгцээ, бодит хэрэглээг физиологийн норм дээр үндэслэн шинэчлэн тогтоон бодлого боловсруулахад ашиглах.

Загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлагыг тогтоосон үндэсний стандартыг мөрдүүлэх.

Загасны аж ахуй, загас боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхэд тавигдах шалгуур, шаардлагыг тогтоох

Хоёрдугаар тэргүүлэх зорилтын хүрээнд:

Сэлэнгэ мөрөн, Орхон, Хараа, Ерөө, Хүдэр, Зэлтэр голд тархан амьдрах нэн ховор, ховор агнуурын ашигтай загасны тархалт, төрөл, зүйл, нөөц, байршил, үржлийн биологи, сүргийн бүтэц, идээш тэжээлийн судалгаа, нөөцийг тогтоох ажлыг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, мониторингийн ажлыг тогтмолжуулах.

Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Хүдэр болон бусад гол, мөрөн нууруудын загасны нөөцийг тогтоох судалгааны ажлыг шинжлэх ухааны болон

мэргэжлийн эрх бүхий байгуулагаар хийлгүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх, нөөцөд түшиглэн Сүхбаатар, Орхон, Ерөө, Мандал, Баянгол, Хүдэр, Түшиг сумдад загасны нөөцийг хамгаалах, үржүүлгийн аж ахуй, боловсруулах үйлдвэр, цех, байгуулах ажлыг уялдуулах зохион байгуулах

Өөрийн орны нөхцөлд тохирсон загас үржүүлгийн технологи боловсруулах

Хушаат сумын “Ишгэнт нуур” ХХК, Сүхбаатар сумын “Батдэм” ББН зэрэг аж ахуйн нэгжүүдийн загас үржүүлгийн газрыг түшиглэн таваарын загасны аж ахуй байгуулах.

Агнуурын загас өсгөн үржүүлэх, хамгаалах, зүй зохистой ашиглах, загас агнуурын бүс нутгийг тодорхой болох загасчлах спортыг хөгжүүлэх

Загас өсгөн үржүүлж буй аж ахуй нэгж, иргэдийн дэмжих зорилгоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Нуур, цөөрөмд агнуурын ач холбогдол бүхий загас өсгөн үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад загас өсгөн үржүүлэх, хамгаалах, зүй зохистой ашиглах тухай сургалт, сурталчилгааны ажлыг байгаль орчны мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

Агнуурын ач холбогдол бүхий загас өсгөн үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг орон нутаг болон БНХАУ, Оросын холбооны Буриад Улсын загасны аж ахуйг танилцуулах, туршлага судлуулах, хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.

Загас үржүүлэг, хамгаалах талаар онол үйлдвэрлэлийн бага хурлыг Сүхбаатар суманд зохион байгуулах.

Гуравдугаар тэргүүлэх зорилт:

Загасны аж ахуй эрхлэх, түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн судалгаанд үндэслэн аймгийн мэдээллийн санг бий болгох.

Загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, серфикаттай болгож, бүртгэлжүүлэх

Загас боловсруулах явцыг эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан орчинд үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлэхэд аймгийн бодлогоор дэмжин хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

Загасны гаралтай түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулан бүртгэлжүүлж, аттестатчилах ажлыг зохион байгуулах.

Орхон, Сүхбаатар сумдын үйлдвэрлэлийн бус аргаар загас боловсруулж байгаа иргэдэд үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

Загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байр, үйлдвэрлэлийн орчин нөхцөл, боловсруулалтын технологи, тоног төхөөрөмжөө сайжруулахад аймаг, сумын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах

Алтанбулаг сумын нутагт орших Гүн нуурыг түшиглэн загас үржүүлгийн бага оврын цехийг байгуулах боломжийг судлан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бие даан амьдрах чадвартай жараахайг байгалийн нөхөн сэргээлтэнд ашиглах, хашлаганд загас өсгөвөрлөн бойжуулах туршилт судалгааг явуулах.

Сүхбаатар, Сайхан, Мандал, Баянгол сумдад загас, загасны гаралтай бүтээгдэхүүн худалдаалах дэлгүүр, ресторан 2-оос доошгүйг байгуулах.

Загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдэд загас боловсруулах, хадгалах, нөөшлөх хялбар технологи, өвчин эмчилгээний судлал, үйлдвэрлэлийн технологи-эрүүл ахуйн мэргэжлийн сургалт зохион байгуулах.

### **Дөрөвдүгээр тэргүүлэх зорилт**

“Утсан загас” аймгийн брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргаж сурталчилж, хөрш зэргэлдээ улс орнуудын туршлагыг судлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

Аймгийн мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн байгуулагуудаар дамжуулан загас, загасан бүтээгдэхүүний шимт чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх ашиг тусыг иргэдэд таниулах гарын авлага, хэвлэмэл материалаар хангах, өдөрлөг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах;

Олон Улсын болон улс, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаанд загас үйлдвэрлэгчдийг нэгдсэн зохион байгуулалттай оролцуулж, борлуулалтанд дэмжлэг үзүүлэх.

Үржүүлгийн аж ахуйн, загас боловсруулдаг аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах.

### **ТАВ: Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

Дэд хөтөлбөрийг 2015-2022 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Эхний үе шат 2015-2018;

Хоёр дахь үе шат 2018-2022;

### **ЗУРГАА: Дэд хөтөлбөрийн хүлээгдэж байгаа үр дүн**

Эхний үе шат 2015-2018 онд:

Аймгийн хэмжээнд гол, мөрний усны амьтад, загасны судалгааг явуулж, агнуурын загасны нөөц тогтоож, загасны аж ахуй эрхлэх, хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болж, загас үржүүлэх, боловсруулах үйлдвэрлэлийн технологитой аж ахуй, загас үржүүлэх, боловсруулах жижиг цех бий болж, загас, загасан бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ нь нэмэгдэж 50 тн-ыг загасыг хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлснээр нэг хүнд ногдох загас, загасан бүтээгдэхүүний хэмжээ 0,1 кг болж, 2014 оны түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.

Усан орчны экологийн төлөв байдал, загасны нөөцийг харуулсан байрзүйн тойм зураг, мэдээллийн нэгдсэн сантай болж, загасыг зориудын аргаар өсгөн үржүүлэх, загас боловсруулах үйлдвэрийг байгуулах техникийн эдийн засгийн үндэслэлийг боловсруулан практикт нэвтрүүлнэ.

### **2 дахь үе шат 2018-2022 он:**

Загасыг зориудын аргаар үржүүлэх бага оврын цехийг байгуулагдснаар аймгийн хэмжээ нөхцөлд тохирсон загас үржүүлэг, боловсруулах технологитой улмаар бие даан амьдрах чадвартай жараахайгаар байгалийн нуур, голыг загасжуулах, шинээр үүсгэн байгуулсан нуур, цөөрөмд таваарын жин хүртэл өвсгөвөрлөн бойжуулах, боловсруулах үйлдвэр, жижиг цех бий болгож, хүн амын хүнсний хэрэгцээнд жил бүр 100 тн загасыг тогтвортой нийлүүлэх, аймгийн хэмжээнд хүн ам 100 тн загасыг хүнсэндээ хэрэглэж, загас, загасан бүтээгдэхүүний хэрэглээний улсын дундаж 0,2 кг-д хүрч, томоохон суурин газруудад загас, загасны гаралтай бүтээгдэхүүн худалдаалах дэлгүүр, рестораны 2-оос доошгүй сүлжээ бий болж, аймгийн загасны нөөцийг тогтоож, улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан “Сэлэнгийн утсан загас” брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргадаг болсон байна.

Хил дамнасан ус тэр дундаа Сэлэнгэ, түүний цутгал голуудын усны амьтад, загасны мониторинг судалгааг тогтмол явуулж улмаар нэн ховор, ховордсон загасны экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх биологийн олон янз байдлыг хамгаалах, байгалийн генофондыг нөхөн сэргээх чиглэлэр мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллана.

### **ДОЛОО: Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

Энэхүү дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих үүргийг Аймгийн Засаг даргын тамгын газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөрийн хэлтэс, Стандарчилал хэмжилзүйн хэлтэс, Байгаль орчин газрууд хамтран хэрэгжүүлнэ.

### **Найм: Дэд хөтөлбөрийн санхүүжилт**

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

Улсын төсөв;

Орон нутгийн төсөв;

Гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл;

Гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалт; Бусад эх үүсвэр.

Аймгийн ирээдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын  
17-ны 60 дугаар тогтоолын хавсралт 2

**“ЗАГАС” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дэд хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцагч	Хөтөлбөрийн санхүүжилт, сая төгрөг		
				Хөрөнгийн эх үүсвэр	2015-2018	2018-2020
1	Аймгийн загасны үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.	<p>“Загас” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах.</p> <p>Хууль бусаар загас барих, худалдах, боловсруулах ажлыг таслан зогсоход чиглэсэн эрхзүйн актуудын хэрэгжилтийг хангахад мэргэжлийн хяналтын болон хууль сахиулах байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах.</p> <p>Хүн амын загас, загасан бүтээгдэхүүний хэрэгцээ, бодит хэрэглээг физиологийн норм дээр үндэслэн шинэчлэн тогтоон бодлого боловсруулахад ашиглах.</p> <p>Загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлагыг тогтоосон үндэсний стандартыг мөрдүүлэх.</p>	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ	Орон нутгийн төсөв	3,0	5,0
		Загасны аж ахуй, загас боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхэд тавигдах шалгуур, шаардлагыг тогтоох	Аймгийн ЗДТГ, ХХ, БОГ	Орон нутгийн төсөв	2,0	4,0
				Бусад	1,0	2,0

	<p>Сэлэнгэ мөрөн, Орхон, Хараа, Ерөө, Хүдэр, Зэлтэр голд тархан амьдрах нэн ховор, ховор агнуурын ашигтай загасны тархалт, төрөл, зүйл, нөөц, байршил, үржлийн биологи, сүргийн бүтэц, идээш тэжээлийн судалгаа, нөөцийг тогтоох ажлыг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, мониторингийн ажлыг тогтмолжуулах.</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ, Мэргэжлийн байгууллага</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>10,0</p>	<p>10,0</p>
<p>Аймгийн гол мөрөн, цөөрөмд тархан амьдрах нэн ховор, ховор агнуурын ашигтай загасны тархалт, төрөл, зүйл, нөөц, байршил, үржлийн биологи, сүргийн бүтэц, идээш тэжээлийн судалгаа, нөөцийг тогтоож, нөөцийг судалгаа, үржүүлэх ажлыг уялдуулах зохион байгуулах</p>	<p>Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Хүдэр болон бусад гол, мөрөн нууруудын загасны нөөцийг тогтоох судалгааны ажлыг шинжлэх ухааны болон мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх, нөөцөд түшиглэн Сүхбаатар, Орхон, Ерөө, Мандал, Баянгол, Хүдэр, Түшиг сумдад загасны нөөцийг хамгаалах, үржүүлгийн аж ахуй, боловсруулах үйлдвэр, цех, байгуулах ажлыг уялдуулах зохион байгуулах</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ</p>	<p>Улсын төсөв</p>	<p>800,0</p>	<p>500,0</p>
<p>Өөрийн орны нөхцөлд тохирсон загас үржүүлгийн технологи боловсруулах</p>	<p>Өөрийн орны нөхцөлд тохирсон загас үржүүлгийн технологи боловсруулах</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>8,0</p>	<p>8,0</p>
<p>Хушаат сумын "Ишгэнт нуур" ХХК, Сүхбаатар сумын "Батдэм" ББН зэрэг аж ахуйн нэгжүүдийн загас үржүүлгийн газрыг түшиглэн таваарын загасны аж ахуй байгуулах.</p>	<p>Хушаат сумын "Ишгэнт нуур" ХХК, Сүхбаатар сумын "Батдэм" ББН зэрэг аж ахуйн нэгжүүдийн загас үржүүлгийн газрыг түшиглэн таваарын загасны аж ахуй байгуулах.</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ, Сумдын ЗД</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>200,0</p>	<p>400,0</p>
<p>Агнуурын загас өсгөн үржүүлэх, хамгаалах, зүй зохиистой ашиглах, загас агнуурын бүс нутгийг тодорхой болох загасчлах спортыг хөгжүүлэх</p>	<p>Агнуурын загас өсгөн үржүүлэх, хамгаалах, зүй зохиистой ашиглах, загас агнуурын бүс нутгийг тодорхой болох загасчлах спортыг хөгжүүлэх</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ, Сумдын ЗД</p>	<p>Бусад</p>	<p>500,0</p>	<p>500,0</p>



	Аймгийн ЗДТГ, БОГ		Орон нутгийн төсөв	5,0	3,0
Загас өсгөн үржүүлж буй аж ахуй нэгж, иргэдийн дэмжих зорилгоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	Аймгийн ЗДТГ, БОГ, Мэргэжлийн байгууллага	Аймгийн ЗДТГ, БОГ, Мэргэжлийн байгууллага	Бусад	2,0	4,0
Загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;			Орон нутгийн төсөв	5,0	3,0
			Бусад	2,0	4,0
Нуур, цөвөрмд агнуурын ач холбогдол бүхий загас өсгөн үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад загас өсгөн үржүүлэх, хамгаалах, зүй зохистой ашиглах тухай сургалт, сурталчилгааны ажлыг байгаль орчны мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.			Орон нутгийн төсөв	3,0	5,0
			Бусад	2,0	4,0

	<p>Затасны аж ахуй эрхлэх, түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийн судалгаанд үндэслэн аймгийн мэдээллийн санг бий болгох.</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>3,0</p>	
	<p>Затасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, серфикаттай болгож, бүртгэлжүүлэх</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>3,0</p>	
	<p>Загас боловсруулах явцыг үзэж өгөх, -агад, аргаагүй аргаар өгөх, агаартай агаартай орчинд үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлэхэд аймгийн бодлогоор дэмжин хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ,</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>1,0</p>	<p>2,0</p>
	<p>Затасны гаралтай түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулан бүртгэлжүүлж, аттестатчилах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,</p>			
	<p>Орхон, Сүхбаатар сумдын үйлдвэрлэлийн бус аргаар загас боловсруулж байгаа иргэдэд үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ, МХГ</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>5,0</p>	<p>5,0</p>
	<p>Затасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг ахлын байр, үйлдвэрлэлийн орчин нөхцөл, боловсруулалтын технологи, тоног төхөөрөмжөө сайжруулахад аймаг, сумын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах</p>	<p>Аймгийн ЗДТГ, БОГ, ХХ</p>	<p>Төсөл, хөтөлбөр зээлд хамруулах</p>	<p>10,0</p>	<p>10,0</p>
	<p>Алтанбулаг сумын нутагт орших Гүн нуурыг түшиглэн загас үржүүлгийн бага оврын цехийг байгуулах боломжийг судлан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бие даан амьдрах чадвартай жараахайг байгалийн нөхөн сэргээлтэнд ашиглах, хашлаганд загас өсгөөрлөн бойжуулах туршилт судалгааг явуулах.</p>	<p>Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,</p>	<p>Бусад</p>	<p>100,0</p>	<p>200,0</p>

3.

	Сүхбаатар, Сайхан, Мандал, Баянгол сумдад загас, загасны гаралтай бүтээгдэхүүн худалдаалах дэлгүүр, ресторан 2-оос доошгүйг байгуулах.	Аймгийн ЗДТГ, ХХААГ, Сумдын ЗД	Орон нутгийн төсөв	2,0	4,0
	Загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдэд загас боловсруулах, хадгалах, нөөшлөх хялбар технологи, өвчин эмчилгээний судлал, үйлдвэрлэлийн технологи-эрүүл ахуйн мэргэжлийн сургалт зохион байгуулах	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,	Бусад	1,0	3,0
	“Утсан загас” аймгийн брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргаж сурталчилж, хөрш зэргэлдээ улс орнуудын туршлагыг судлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх.	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,	Орон нутгийн төсөв	5,0	10,0
	Аймгийн мэдээллийн хэрэгсэл, эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан загас, загасан бүтээгдэхүүний шимт чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх ашиг тусыг иргэдэд таниулах гарын авлага, хэвлэмэл материалаар хангах, өдөрлөг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ, ЭМГ	Орон нутгийн төсөв	2,0	4,0
	Олон Улсын болон улс, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаанд загас үйлдвэрлэгчдийг нэгдсэн зохион байгуулалттай оролцуулж, борлуулалтанд дэмжлэг үзүүлэх.	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,	Бусад	1,0	2,0
4.	Аймгийн үржүүлгийн аж ахуй, загас боловсруулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг сурталчилах, борлуулалтанд дэмжлэг үзүүлэх.	Аймгийн ЗДТГ, ХХААГ, БОГ,	Орон нутгийн төсөв	1571,0	2583,0
	НИЙТ САНХҮҮЖИЛТ				



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17-ны өдөр

Дугаар 61

Сүхбаатар

**Орон тооны бус зөвлөл байгуулах тухай**

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10, 11, 12 дугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.2.2-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын 17-ны  
өдрийн 61 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Орон тооны бус зөвлөлийн дарга:-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын дарга

Орлогч дарга: -Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:-Аймгийн Тагнуулын газрын дарга

-Аймгийн Цагдаагийн газрын дарга

-Аймгийн Онцгой байдлын газрын дарга

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Хил хамгаалах ерөнхий газрын 0243-р ангийн захирагч

-Аймгийн Татварын хэлтсийн дарга

-Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний газрын дарга

-Аймгийн Цэргийн штабын дарга

-Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын 17-ны  
Өдрийн 61 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**ЗОРИЛГО.** Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан/, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль /2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан/-ын заалтыг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх, ҮАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд тус тусын үйл ажиллагааны хүрээнд ҮАБ-ыг хангахад сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн хүчин зүйлүүдийн талаар мэдээ, мэдээлэл солилцож танилцуулах, орон нутагт үүнтэй холбоотой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хор хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх, арилгах, шалтгаан нөхцлийг судлан тогтоох, ҮАБЗ-ийн Ажлын албанд мэдээлэхэд оршино.

### **Нэг.Журам гаргах хууль зүйн үндэслэл:**

1.1 Үндэсний аюулгүй байдлын үзэл баримталын 4 дүгээр зүйлийн 1.1, 1.3, 1.5, 1.6, 1.8, 2.2, 2.6 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 10 дугаар зүйлийн 1, 11 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 1, 3, 16 дугаар зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 4 дахь заалтууд болно.

### **Хоёр. Харилцан ажиллах байгууллагууд**

2.1 Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудыг уялдуулан зохицуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус аймгийн зөвлөлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс байгуулна.

Морин хэмжүүр	1	20000	20000
Урал хөрөө	1	250000	250000
Хөнгөн цагаан шат	2	10000	20000
Гэрийн дээврийн төмөр	1	50000	50000
Дугуй хөрөөний ир	4	10000	40000
1100 кв-ын автомат сэнс	1	365000	365000
Төмөр пийшин яндангийн хамт	2	25000	50000
Цонхны төмөр хамгаалалт.	63	87000	5481000
Цонхны жижиг төмөр хамгаалалт.	2	25000	50000
Хайлшин тогоо	1	15000	15000
Сийлбэртэй майга ширээ	1	15000	15000
Эрээн модон авдар	2	5000	10000
Эрээн модон хослол хайрцаг	2	3000	6000
Хээ наасан шар авдар	2	5000	10000
Хээтэй модон шкаф	1	5000	5000
Том ширмэн тогоо	1	150000	150000
Том эрээн айрагны хул	1	3000	3000
3 литрийн данх	1	18000	18000
1100 квт-ын насос	1	350000	350000
Хогийн жижиг төмөр сав	8	65000	520000
Хогийн том төмөр сав	4	85000	340000
550 квт-ын носас	1	150000	150000
Хогийн том төмөр сав	5	94000	470000
Хогийн жижиг төмөр сав	3	71900	215700

Идээний модон цар	1	9000	9000
Боовны тавиур	5	1000	5000
Боов зөөх төмөр онгоц	1	2000	2000
60 литр пивор сав	1	17000	17000
Төмөр пийшин харуулын байранд	1	15000	15000
Иштэй хүрз	4	4800	19200
Худгийн носас	1	450000	450000
Орос тоо цохигч машин	2	65000	130000
Ус татах хондо носас	1	270000	270000
Ширээний микрофон	5	35000	175000
Худгийн мотор	1	330000	330000
Том үдэгч	1	47000	47000
Өсгөгч	1	20000	20000
Зургын аппарат	1	3406000	3406000
Галын багаж хэрэгсэл	1	11026000	11026000
220 квт-ын цахилгаан үүсгүүр	1	350000	350000
320квт-ын цахилгаан үүсгүүр	1	250000	250000
Хамгаалах баг	1	25000	25000
Төслийн зуух	1	280000	280000
Айргийн ваар	1	100000	100000
Шанаг	4	3299	13196
Туг	1	244400	244400
Өрөөний сэнс	5	25000	125000
Дүш	3	130000	390000
Прожектор	3	35000	105000
Өрөөний том сэнс	1	170000	170000
Мэдрэмтгий гэрэл	5	28000	140000
Цонхны хөшиг	11	42000	462000
Хятад хөрөө	1	140000	140000
Хөөрөг	3	1000000	3000000
Даацын тавиур	6	350000	2100000
Хийдийн уран зураг/ Эрдэнэхүүгийни өрөөнд/	1	5000000	5000000
Гэрэл зургийн альбом	1	2875000	2875000
ХЕРОК принтер 3019	1	380000	380000
принтер 1010	1	190000	190000

Хавтгай дэлгэц.процессор.гар .мауз	1	850000	850000
Бичгийн төмөр сейф	1	50000	50000
Бичгийн ширээ	1	539000	539000
Зөөлөн сандал	2	209000	418000
Бичиг хэргийн шүүгээ	1	489000	489000
Цаас үдэгч том	1	36000	36000
Олон залгуур	1	5000	5000
Санхүүгийн тэмдэг	1	10000	10000
Тоо дугаарлагч	1	9000	9000
Цаас үдэгч жижиг	1	300	300
Тооны машин	1	15000	15000
Нийт дүн	0	0	90806096



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын  
17-ны өдрийн 62 дугаар тогтоолын хавсралт 4

**АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР  
ХИЙГДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ЗАРДЛУУД				
№	Хөрөнгийн нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд/төгрөгөөр/
1	Сүмийн будаг сэргээх, гадна, дотор тохижилт засвар, багана засвар 1973-2010 он		250,628,850	250,628,850
2	Ринбүчи багшийн хандиваар /80 гаруй мянган ам.доллор/		699,360,600	699,360,600
3	Алтан шармал луу /25000 доллор/		218,550,200	218,550,200
4	Дээврийн засварын материалууд		872,246,250	872,246,250
5	АНУ-ын Элчин сайдын яам Сүмийн цахилгааны монтажийг бүхэлд нь шинэчилсэн /2011-2012/		300,000,000	300,000,000
6	ЮНЕСКО 1979-1989 онд МОН/75/001 төсөл хэрэгжүүлсэн		938,833,000	938,833,000
7	Тарьсан мод хар мод-251, нарс-1200 ширхэг		80,000,000	80,000,000
	Нийт дүн			3,359,618,900



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 65

Сүхбаатар

**Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар  
худалдах тухай**

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, хавсралтад дурьдсан тээврийн хэрэгслүүдийг үндсэн байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслэн дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, дуудлага худалдааны доод үнийг баталсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын 17-ны  
өдрийн 65 дугаар тогтоолын хавсралт  
**АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ**

Байууллага аж ахуйн нэр	Хөрөнгийн нэр төрөл машин марк, улсын дугаар	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Үйлдвэрлэсэн улс	Тоо ширхэг	Дансны анхны үнэ	Байгуулсан эргэлдэл	Үндсэн санал	орон нутгийн өмчийн алба	Засаг даргын санал	Аймгийн иргэдийн хурлын санал	Дуудлага худалдааны доод үнэ
Ерөө сумын Бугант тосгон ЭМТ	Уаз-31512 СБА60-41	Автомашин	2002	ОХУ	1	9045000	9045000	Актлах	Дуудлага худалдаа			
Ерөө сумын Бугант тосгон ЭМТ	Мицубуши Пажеро СБА48-37	Автомашин	1997	Япон	1	12000000	12000000	Актлах	Дуудлага худалдаа			
Сэлэнгэ аймаг Зоонозын өвчин судлалын төв	Уаз-31512 СБА00-87	Автомашин	2004	ОХУ	1	12388000	12388000	Актлах	Дуудлага худалдаа			
ААА-1 Нүүгүяаеи атаеаи +006аа	Пурган УАЗ-452В СБА 26-66	Автомашин	1992	ОХУ	1	5788800	5788800	Актлах	Дуудлага худалдаа			
Тээвэр авто замын газар	Тоёота Прадо СЭА 00-91	Автомашин	1998	Япон	1	22588500	22588500	Актлах	Дуудлага худалдаа			
Баянгол ЗДТГ	Тоёота чезер-100 СЗУ 23-78	Автомашин	1996	Япон	1	3500000	3500000	Дуудлага худалдаа	Дуудлага худалдаа			
Алтанбулаг сум ЗДТГ	Сузуки СБА95-66	Бага оврын ачааны автомашин	1995	Япон	1	4500000	4500000	Актлах	Дуудлага худалдаа			
Нийг дүн						69810300	69810300	Актлах	Дуудлага худалдаа			



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 67

Сүхбаатар

**Булдан-аагийн Ганболдыг Монгол улсын  
Гавьяат механикжуулагч цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж, амжилт гаргасныг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Цэгээн хуст ХХК-ний захирал Булдан-аагийн Ганболдыг Монгол улсын Гавьяат механикжуулагч цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 69

Сүхбаатар

**Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр  
өргөмжлөх тухай**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 81 дүгээр тогтоолоор баталсан Сэлэнгэ аймгийн шагналын журмыг үндэслэн үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Эх түүх, үндэсний соёлоо дээдэлж, аймгийн хөгжил дэвшил нийгмийн сайн сайхны төлөө оруулсан хөдөлмөр бүтээл нэр хүндийг олонд дуурсгасан амжилт, гавьяат үйлсийг нь үнэлж Өөлдийн Бавууг Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилсүгэй.

2.”Хүндэт иргэн”-ний дагалдах мөнгөн шагналыг “Сэлэнгэ аймгийн шагналын журам”-д заасны дагуу төсвөөс гаргахыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д зөвшөөрсүгэй.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17-ны өдөр Дугаар 70

Сүхбаатар

**Ой тэмдэглэх тухай**

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой тэмдэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөө сумын Эрүүл мэндийн төв байгуулагдсаны 80 жилийн ойг 2015 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойгоо угтаж байгууллага, хамт олныхоо идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллахыг тус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Э.Нинжбадам/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр Дугаар 70

Сүхбаатар

**2015 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны  
тоо хэмжээ тогтоох тухай**

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцээд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.2, Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалт, Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны А/214 тоот тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2015 онд ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр агнуурын бүс нутгийн хамт хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нар болон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/ нар тус тус даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 06 дугаар сарын  
29-ны өдрийн 71 дүгээр тогтоолын хавсралт

### АХУЙН ЗОРИУЛАЛТААР 2015 ОНД АГНАХ, БАРИХ АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭНИЙ ДЭЭД ХЯЗГААР

№	Сумын нэр	Бор гөрөөс агнах		Зэрлэг гахай агнах		Залгах барих		Хэмжээ толгой
		агнуурын бүс нутгийн нэр,	хэмжээ толгой	агнуурын бүс нутгийн нэр,	хэмжээ толгой	алнуурын бүс нутаг, хамрах хүрээ		
1	Алтанбулаг	Ивцэг-Хангай	4	Ивцэг-Хангай	2	-	-	-
		Хазай	3	Хазай	2	-	-	-
2	Баруунбүрэн	Ар бургалтай	4	Ар бургалтай	3	-	-	-
		Сэндэн	4	-	-	-	-	-
3	Баянгол	Баян	3	Баян	1	1.Баян Суудалаас- Дожоо вангийн булан /18,72км Хараа гол/ 2.Баянбулагаас- Дүгзрийн тохой/39,1 Хараа гол/		100
		Бугант	3	Бугант	3	1.Ерөө- Ялбагийн бэлчирээс- Ерөө- Хэрэнгийн бэлчир/39,14 Ерөө гол / 2.Ерөөгийн гүүрнээс- дагнайн Өндөр уул хүртэл 36,59км Ерөө гол 3.Ерөө- Бүхлэйн бэлчирээс- дааган дэлийн үзүүр /сумын хил/53,35км Ерөө гол		200
4	Ерөө	Бэрлэг-Ялбаг	4	Бэрлэг-Ялбаг	4			
		Бүхлэйн	4	Бүхлэйн	2			
5	Жавхланта	Цагаан даваа	2	-	-	Шар Хад уулаас- Ерөөгийн гүүр хүртэл тус сумын хэсэг /40,37 км/ Ерөө гол		100
6	Зүүнбүрэн	Хоёр давааны	2	-	-	1.Улаан ямаатаас- Доргог тал /43,16км Сэлэнгэ мөрөн/ 2. Зур Хангайн үзүүр- Хар усны уулаар /23,43км Орхон гол/		100
		Ар өвөр гахайт	4	Ар өвөр гахайт	2	Хараа Тарнийн бэлчирээс-Хараа Бороогийн бэлчир хүртэл/42,86км Хараа гол/		100
7	Мандал	Түнхэл	3	Түнхэл	4			
		Шар хөтөл	2	-	-	Шар хөтөл- Хар нүдэн/ 43км/		200
9	Орхонтуул	Шар Хад- өндөр улаан	4	-	-	1.Өлзийт амнаас- Орхон, Туулын бэлчир хүртэл /28,69км Туул гол/ 2.Цагаан тохой бүхэлдээ/ 28,69км Орхон гол/		200
		Мангилын нуруу	3	-	-	Хуурай сайраас- Хуузын хушуу- Орхон-Хараагийн бэлчир /52,03км Орхон гол/		100
10	Сайхан	-	-	-	-			100



11	Сант	Тэлд-Хушаат	4	Тэлд-Хушаат	2	1.Урт булаг- Баянгийн овоо үзүүр /11,67км Ивэн гол/ 2.Ивэнгийн адаг- Ногоон толгой- Өнгөт шороот /9,17км Орхон гол/	50
12	Түшиг	Номт өндөр	3	Номт өндөр	2	Нарийн Шүрэнгийн адгаас- Улаан овооны үзүүр хүртэл /47,24км Зэлтэр гол/	100
		Ар шүрэн	3	Ар шүрэн	3		
		Хажингийн нуруу	3	Хажингийн нуруу	3		
13	Хушаат	Ар Тойлбын	5	Ар Тойлбын	4	1.Таван нарстай уулын араас – Сүүжийн зүүн амины адаг /8,87км Сэлэнгэ мөрөн/ 2.Таван толгойн хэсэг /12,45км Орхон гол/	100
14	Хүдэр	Тарвагатай	3	Тарвагатай	2	1. Цагаан Шилүүстэйн дээд хошуу- Хүдэр Шоргоолжийн бэлчир /22,73км Шоргоолж гол/ 2.Наймын гүүрнээс- Хүдэрийн адаг /30,02км Хүдэр гол/	100
		Малгайт Шоргоолж	4	Малгайт Шоргоолж	4		
				Сэвсүүл	2		
15	Цагааннуур	Сангилтай	3	Сангилтай	2	1.Шүрэнгийн адгаас- Доод хоолой /32,29км Сэлэнгэ мөрөн/ 2.Толгойн хоолой- хар усны үзүүр /36,18км Сэлэнгэ мөрөн/	150
		Шүрэн- Баруун гол	3	Шүрэн- Баруун гол	3		
16	Шаамар	-	-	-	-	1.Талын Тогзорын урд тохойтоос- орхон Ерөөгийн бэлчир/ 18,2км Ерөө гол/ 2.Орхон-Ерөөгийн бэлчирээс – Их Бургэз, Орхоны гүүр хүртэл /26,18км Орхон гол/	200
17	Сүмбаатар Дун:	-	-	-	-	Орхоны гүүр- Орхон Сэлэнгийн бэлчир	200
							2000

..... оОо .....



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр

Дугаар 72

Сүхбаатар

**Баяр наадмын төсөв батлах тухай**

Монгол улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ардын хувьсгалын 94 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 84 жилийн ой үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг 50,000,000 /тавин сая/ төгрөгөөр баталсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр Дугаар 74

Сүхбаатар

**Шаравын Норовсамбууг Монгол улсын  
“Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Авто тээвэр, газар тариалангийн салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улсын хэрэгцээт бараа болон буудайг амжилттай тээвэрлэж, газар тариалангийн салбарт шинэ технологийг нэвтрүүлэн хүн ардыг эрүүл аюулгүй хүнсээр хангах үйлсэд оруулсан хөдөлмөр зүтгэлийг нь үнэлэн Түшиг сумын Анхтамир ХХК-ийн захирал Шаравын Норовсамбууг Монгол улсын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр Дугаар 75

Сүхбаатар

**Санжаагийн Батсүхийг Монгол Улсын  
“Гавьяат тамирчин” цолоор шагнуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, их спортоор олон улс, тив, дэлхийн их наадмын тавцанд эх орныхоо нэрийг дуурсгаж, дэлхийд өрсөлдөх чадвартай олон арван шилдэг тамирчдыг төрүүлэн гаргаж, чөлөөт бөхийн спортыг хөгжүүлэх үйлст оруулсан бодитой хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэн Санжаагийн Батсүхийг Монгол Улсын Гавьяат тамирчин цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр Дугаар 76

Сүхбаатар

**Шагдарсүрэнгийн Эрдэнэбилэгийг Монгол улсын  
“Гавьяат дасгалжуулагч” цолоор шагнуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улс болон Сэлэнгэ аймагт Мото спортыг хөгжүүлэх үйлсэд олон жилийн хөдөлмөрөө зориулан ажиллаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон тамирчин бэлтгэн гаргаж, биеийн тамир спортын хөгжил цэцэглэлтийн төлөө оруулсан хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Шаамар сумын иргэн Шагдарсүрэнгийн Эрдэнэбилэгийг Монгол Улсын “Гавьяат дасгалжуулагч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 29-ны өдөр Дугаар 81

Сүхбаатар

**Зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас аймгийн төвүүдэд хэрэгжүүлж байгаа “1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Мандал суманд баригдаж байгаа 126 айлын орон сууцны барилга угсралтын гадна цахилгаан хангамж, гадна бохир, цэвэр дулааны шугамын угсралтын ажлын зардлыг “Төрийн орон сууц корпораци” ТӨҮГ-ын зээлээр санхүүжүүлэх гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д олгосугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 02-ны өдөр Дугаар 85

Сүхбаатар

**Тогтоолд өөрчлөлт оруулж, тогтоол  
хүчингүй болгох тухай**

Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Монгол улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 148 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтуудад Сайхан суманд арчилгааны огтлолоор 100 шоо метр, цэвэрлэгээний огтлолоор 400 шоо метр шинэс модыг хэрэглээний зориулалтаар Баруунбүрэн сумын нутгаас бэлтгэхээр нэмж оруулсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Батзориг/ нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 02-ны өдөр Дугаар 86

Сүхбаатар

**Зөвшөөрөл олгох тухай**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Ерөө сумын 2-р багт Христийн шашны “Ерөө Баптист” сүм байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд мэдэгдэж, үйл ажиллагааныхаа тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр ирүүлж байхыг сүмийн ахлагчид зөвлөсүгэй.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 02-ны өдөр Дугаар 87

Сүхбаатар

**Тогтохын Сэлэнгээг Монгол улсын Гавьяат эмч  
цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн салбарт тасралтгүй олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг нь өндрөөр үнэлж аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн их эмч Тогтохын Сэлэнгээг Монгол улсын Гавьяат эмч цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 02-ны өдөр Дугаар 89

Сүхбаатар

**Зөвшөөрөл олгох тухай**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Ерөө сумын 3-р багт Христийн шашны “Бугант Баптист” сүм байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд мэдэгдэж, үйл ажиллагааныхаа тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр ирүүлж байхыг сүмийн ахлагчид зөвлөсүгэй.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 02-ны өдөр Дугаар 90

Сүхбаатар

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган аймаг, сумын жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын  
02-ны өдрийн 90 дүгээр тогтоолын хавсралт

## **АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Аймгийн ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн байдал**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2015 оны эхний хагас жилийн байдлаар 240 иргэн, аж ахуйн нэгж ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнд 380 иргэн ажлын байраар хангагдаж байна.

Бүх сумдыг ахуйн үйлчилгээгээр иж бүрэн хангах хөрөнгө мөнгөний бололцоо хангалтгүйгээс сумдад ахуйн үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй байдаг бөгөөд үүнийг аль болох төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд хийж хэрэгжүүлэхээр зорьж байгаа хэдий ч хүссэн үр дүнд хүрэхгүй байна.

Ахуй үйлчилгээний цэг салбаруудыг үйлчилгээ бүрээр нь авч үзвэл:

Үс засах үйлчилгээ – Мандал, Сайхан, Сүхбаатар зэрэг томоохон сумдад 730-790 хүнд нэг үсчин ноогдож байхад 2100-3000 хүн амтай Сант, Баруунбүрэн, Орхон зэрэг суманд энэ үйлчилгээ байхгүй байна.

Гоо заслын үйлчилгээ – Сүхбаатар, Алтанбулаг, Цагааннуур, Сайхан, Мандал, Баянгол зэрэг томоохон суманд үйл ажиллагаа явуулж байгаа боловч бусад сумдад эрэлт хэрэгцээтэй байна.

Хувцас захиалгын үйлчилгээ – Ихэнх сумдад үйл ажиллагаа явуулж байна.

Гутал засварын үйлчилгээ – Алтанбулаг, Ерөө, Мандал, Сант, Цагааннуур, Баянгол, Сайхан, Сүхбаатар зэрэг 8 суманд үйл ажиллагаа явуулж байна.

Халуун усны үйлчилгээ – Сант, Түшиг суманд байхгүй.

Мөн цаашид гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, гар утасны засвар үйлчилгээ, хими цэвэрлэгээ, компьютер засвар, дугуй засвар, машин угаалга зэрэг үйлчилгээний цэгүүдийг шинээр байгуулах шаардлагатай байна.

Дээрхи байдлаас үзэхэд ахуйн үйлчилгээний хүртээмж аймгийн хэмжээнд харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг өмнөх дэд хөтөлбөр батлагдсан 2011 онтой харьцуулан хүснэгтээр харуулав.



Сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа ахуй үйлчилгээний цэгүүдэд үйл ажиллагаа явуулах тохилог ажлын байр байхгүй, дадлага туршлага хангалтгүй байна.

Ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хувьд Сүхбаатар сумын Орхон баг, Хушаат суманд орон нутгийн өмчийн барилгатай. Эдгээр сумдад ахуй үйлчилгээний төв байгуулахаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг авч, түрээсийн гэрээгээр өгөхөөр бэлтгэл ажлыг хангаж байна.

Мөн Жавхлант суманд орон нутгийн хөгжлийн сангаар хуучин байр худалдаж аван ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар засварлан ашиглалтанд оруулаад байна.

Ерөө, Түшиг сумын ахуй үйлчилгээний төвийн шинэ барилгын гүйцэтгэл 60-80 хувьтай, Сүхбаатар сумын 5 дугаар багт ахуй үйлчилгээний барилга баригдан 2013 онд ашиглалтанд орж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

#### Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор батлагдсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, түүнчлэн аймгийн ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэн энэ салбарт ажиллагсадын ур чадварыг сайжруулах, санхүү эдийн засаг, эрх зүйн орчин нөхцлийг бүрдүүлэх болон цаашид баримтлах бодлого, зорилтыг тодорхойлох, удирдлага арга зүйгээр хангах, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

#### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвийн тоог нэмэгдүүлэн үйлчилгээг ойртуулах, ажилгүйдлийг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөнийг багасгахад хөтөлбөрийн зорилго оршино.

#### **2.2. Энэхүү зорилгыг дараах зорилтоор хэрэгжүүлнэ**

2.2.1.Улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг түшиглэн төв суурин газруудад ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх

2.2.2.Албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг дэмжих

2.2.3.Салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

2.2.4.Ахуйн үйлчилгээний салбарт бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээ (Кластер) - г хөгжүүлэх;

2.2.5.Ахуйн үйлчилгээний нэр төрлийг олшруулах

### **2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:**

- 2.3.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, сум, орон нутгийн иргэдийн хэрэгцээтэй уялдсан байх;
- 2.3.2. Үйлчилгээний салбарын хууль тогтоомж, стандарт, хөгжлийн чиг хандлагатай уялдсан байх;
- 2.3.3. Үйлчилгээ нээлттэй, хүртээмжтэй, уян хатан байх;
- 2.3.4. Бүх талуудын бодит оролцоог хангасан байх;

### **Гурав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

#### **3.1. Хөтөлбөрийг 2015-2018 онд хэрэгжүүлнэ.**

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг түшиглэн төв суурин газруудад ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1. Сум орон нутагт улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглан ахуйн үйлчилгээний салбарыг байгуулах, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;

4.1.2. Ахуйн үйлчилгээний салбарт шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг, урамшуулал олгох.

4.1.3. Явуулын ахуйн үйлчилгээний хэлбэрийг бүх талаар дэмжих;

4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг дэмжих зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.2.1. Ахуйн үйлчилгээ эрхлэн ашиг орлогоо нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

4.2.2. Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ (лизинг)-нд хамруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.3. Хөнгөлөлттэй зээл, хандив, тусламжид хамруулахад дэмжлэг үзүүлэх

4.3. Салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.3.1. Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсадыг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтанд хамруулах;

4.3.2. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн сургалтад хамруулах;

4.3.3. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд нарийн мэргэжлийн ажилтан сургаж бэлтгэх, залгамж чанарыг хадгалах;

4.4. Ахуйн үйлчилгээний салбарт бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээ (Кластер)-г хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.4.1. Ахуй үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан төрийн бус олон нийтийн байгууллага, холбоодын дэвшилтэт санал санаачлагыг бүх талаар дэмжиж ажиллах;

4.4.2. Бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээний зохион

байгуулалтанд орсон ахуйн үйлчилгээний байгууллага, хамт олны бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжин хамтран ажиллах;

4.4.3. Туршлага судлуулах ажлыг зохион байгуулах;

4.5. Ахуйн үйлчилгээний нэр төрлийг олшруулах зорилтын хүрээнд:

4.5.1. Ахуйн үйлчилгээний төвүүдэд 2-3 шинэ нэр төрлийн үйлчилгээ бий болгох;

4.5.2. Сум тус бүрийн онцлог, газарзүйн байрлал, хүн амын тоо, дэд бүтцийн хөгжил, иргэдийн эрэлт хэрэгцээ зэргээс шалтгаалж ахуйн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.5.3. Сум бүрийг үс засах, халуун усны үйлчилгээ үзүүлэх газруудтай болгох;

### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт, удирдлага зохион байгуулалт**

5.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

5.1.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

5.1.2. Сум хөгжүүлэх сан;

5.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

5.1.4. Орон нутгийн хөгжлийн сан;

5.1.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

5.2. Удирдлага зохион байгуулалт:

5.2.1. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана;

5.2.2. Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, жил бүр дүгнэж ажиллана.

5.3. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ:

5.3.1. Хөдөлмөрийн хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ.

5.3.2. Хөгжлийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, цаашид авах арга хэмжээг боловсруулна.

### **Зургаа. Хөтөлбөрийн үр дүн**

6.1. Ахуйн үйлчилгээний төв, үйлчилгээ эрхлэгчдийн тоо жил бүр 20-30 хувиар нэмэгдсэн байна.

6.2. Ахуйн үйлчилгээний салбар дахь шинэ ажлын байрны тоо жил бүр 30-аас доошгүй хувиар нэмэгдсэн байна.

6.3. Тус салбарын албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжсэн иргэдийн тоо нэмэгдсэн байна.

6.4. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадвар, үйлчилгээний стандарт дээшилсэн байна.

6.5. Орон нутаг дахь ахуйн үйлчилгээний нэр төрөл жил бүр нэмэгдсэн байна.

### **Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

7. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:



- 7.1. Үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээний өсөлт
- 7.2. Ахуйн үйлчилгээний эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ болон ажлын байрны өсөлт
- 7.3. Улс, бүсийн уралдаан тэмцээнд хамрагдсан үзүүлэлт, үзүүлсэн амжилт
- 7.4. Тохирлын баталгаатай ахуй үйлчилгээний нэр төрөл, тооны өсөлт
- 7.5. Сайн дурын баталгаажуулалтанд хамрагдсан ахуй үйлчилгээний нэр төрөл цэгийн тоо.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 02-ны өдөр      Дугаар 91

Сүхбаатар

**Тогтоол хүчингүй болгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 2015 оны 04 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дүрэм” шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 28-ны өдөр Дугаар 97

Сүхбаатар

**Журам батлах тухай**

Монгол улсын “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Тэмдэгтийн хураамжийн хэмжээ батлах тухай” 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.”Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих” журмыг хавсралтаар баталж 2016 оны нэгдүгээр сарын 01-ны өдрөөс аймгийн нутаг дэвсгэрт дагаж мөрдсүгэй.

2.Уг журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих” ажлын хэсэг, холбогдох хэлтэс газруудад үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг мөрдөж эхэлсэн өдрөөс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор баталсан журмыг хүчингүйд тооцсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын  
28-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралт

## **“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ” ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Хууль тогтоомжинд өөрөөр заагаагүй бол тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид энэ журам нэгэн адил хамаарна.

Хоёр. Согтууруулах ундаа худалдах, түүгээр  
үйлчлэх зөвшөөрөл олгох

2.1.Аймгийн Засаг дарга дэргэдээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн хүсэлт, холбогдох материалыг хүлээн авч судлан санал дүгнэлт гаргах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллана.

2.2.Ажлын хэсгийн даргаар аймгийн Засаг даргын орлогч, нарийн бичгийн даргаар аймгийн Засаг даргын тамгын газрын худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, гишүүдэд Мэргэжлийн хяналтын газар, Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжилзүйн төв, Цагдаагийн газрын холбогдох ажилтнууд орно.

2.3.Тусгай зөвшөөрөл олгох ажлын хэсгийн нарийн бичгийн дарга ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулах ба зөвшөөрөл олгох, хугацаа сунгахад шаардлагатай материалыг бүрдүүлэн авч 30 хоногт багтаан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

2.4.Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ доорх бичиг баримтын хамт ажлын хэсгийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.Үүнд :

- Сумын Засаг даргын санал албан тоотоор
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
- Аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтийн хуулбар
- Улсын стандартын шаардлагыг бүрэн хангасныг баталгаажуулсан Тохирлын гэрчилгээний хуулбар
- Татвар бүрэн төлсөн тухай тодорхойлолт
- Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний байрны гадна, дотор зурагнууд
- Аж ахуйн нэгжийн хүсэлт

2.5.Ажлын хэсгийн гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын Захирамжаар олгоно.

2.6.Тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гармагц “Тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2011 оны 67 дугаар тогтоолын дагуу:

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход:

-Аймгийн төвийн суманд-400000 төгрөг

-Бусад суманд 250000 төгрөг

Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход:

-Аймгийн төвийн суманд 150000 төгрөг

-Бусад суманд 80000 төгрөг

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход:

-Аймгийн төвийн суманд 800000 төгрөг

-Бусад суманд 500000 төгрөг

Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход:

-Аймгийн төвийн суманд 300000 төгрөг

-Бусад суманд 200000 төгрөг

Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 100000 төгрөг тус тус тэмдэгтийн хураамжийн дансанд тушааж, баримтыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгч тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авна.

2.7.Тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгоно.

2.8.Нэг аж ахуйн нэгжид 2 –оос илүү зөвшөөрөл олгохгүй байх.

Гурав. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

3.1.Аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт, материалыг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 14-еос доошгүй хоногийн өмнө ажлын хэсгийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.

3.2.Тусгай зөвшөөрөл сунгахад дараах материалыг бүрдүүлсэн байна.Үүнд:

- Сумын Засаг даргын санал албан тоотоор

- Аймгийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтийн хуулбар

- Улсын стандартын шаардлагыг бүрэн хангасныг баталгаажуулсан

Тохирлын гэрчилгээ- хуулбарын хамт

- Татвар бүрэн төлсөн тухай тодорхойлолт

3.3.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга материалыг шалгаж хүлээн авч, зөвшөөрөл сунгах асуудлыг ажлын 5 өдөрт багтаан шийдвэрлүүлнэ.

3.4.Тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын захирамжаар сунгана.

3.5.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шийдвэр гармагц “Тэмдэгтийн

хураамжийн хэмжээг батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2011 оны 67 дугаар тогтоолын дагуу:

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:

-аймгийн төвийн суманд-150000 төгрөг

-бусад суманд 80000 төгрөг

Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:

-аймгийн төвийн суманд 50000 төгрөг

-бусад суманд 30000 төгрөг

Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад:

-аймгийн төвийн суманд 300000 төгрөг

-бусад суманд 150000 төгрөг

Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход:

-аймгийн төвийн суманд 150000 төгрөг

-бусад суманд 100000 төгрөг тус тус тэмдэгтийн хураамжийн дансанд тусааж, баримтыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгч Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авна.

#### Дөрөв. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

4.1.Эрх бүхий байгууллагын шалгалтаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх нөхцөл үүссэн нь тогтоогдсон бол ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.1.1.Аж ахуйн нэгж нь 2 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй, энэ тухайгаа ажлын хэсэгт албан ёсоор мэдэгдээгүй

4.1.2.Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах байршлаа өөрчилсөн, энэ тухайгаа албан ёсоор мэдэгдээгүй

4.1.3.Согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ эрхлэх талаар сум орон нутгийн тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн талаар тухайн орон нутаг түдгэлзүүлэх санал гаргасан

4.1.4.Тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрыг бусдад түрээсээр ашиглуулсан

4.1.5 Тусгай зөвшөөрлийг сунгах хугацаа 1 сараас хэтэрсэн тохиолдолд.

4.2.Дээрх зөрчлүүдийг гаргасан аж ахуйн нэгжийн асуудлыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэр гаргана.

4.3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаа гаргасан зөрчлөөс шалтгаалан 3-6 сар байна.

4.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай аж ахуйн нэгжид албан ёсоор мэдэгдэнэ.

4.5.Тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн зөрчил арилсан нөхцөлд тухайн аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

5.1. Дараах зөрчлүүдийг гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргана.

5.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан

5.1.2. Аж ахуйн нэгж татан буугдсан

5.1.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн ажиллуулсан

5.1.4. 21 нас хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдсан, үйлчилсэн

5.1.5. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн зөрчлийн тэмдэглэлд 2 ба түүнээс дээш зөрчил тэмдэглүүлсэн

5.1.6. Стандартын бус согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн

5.1.7. Зөвшөөрөлд заагдсан байрлал, чиглэлийг дур мэдэн өөрчилсөн

5.1.8. Зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн

5.1.10. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн зөрчил давтагдсан

5.1.11. Холбогдох хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулах.

Зургаа. Тусгай зөвшөөрөл олгоход тавих үндсэн шаардлага.

6.1. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь “Худалдаа, худалдааны газрын үйлчилгээ 5021:2007” Улсын стандарт”-ыг 100 хувь, Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь “Хоолны газрын үйлчилгээ MNS- 4946:2005” Улсын Стандартыг 90 хувь хангасан байна.

6.2. Худалдаа үйлчилгээ явуулах байр нь төв суурин газарт 40 м кв-аас багагүй, багийн төв жижиг сууринд 24 м кв-аас багагүй зайд байрлаж, холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд хүнсний аюулгүй байдал, барилга байгууламж, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагаа, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн шаардлагыг хангасан байна.

6.3. Худалдаа, үйлчилгээ явуулах байрны доторх орчныг бүрэн камержуулсан байна.

6.4. Худалдаа, үйлчилгээний газрууд кассын машинтай байна.

6.5. Худалдаа, үйлчилгээний газрын онцлогийг харуулсан дүрэмт хувцас, энгэрийн тэмдэг хэрэглэж хэвшсэн байна.

6.6. Худалдаа, үйлчилгээний газар нь гадна орчны талбайдаа иж бүрэн тохижилт хийж, \талбайг цардах, зүлэгжүүлэх, авто машины зогсоол\ цэвэрлэгээ, хог зайлуулах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

6.7. Худалдан борлуулж байгаа согтууруулах ундааг үйлдвэрлэсэн, импортолсон, нийлүүлсэн аж ахуйн нэгжийн үндсэн баримттай, бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лабораторид улирал бүр шинжлүүлсэн шинжилгээний бичигтэй байна.

6.8. Үйлчилгээний газар нь эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. \бие засах газар, гар угаалтуур\

6.9. Архидалттай тэмцэх арга хэмжээг сурталчилах, энэ чиглэлээр зохиогдож байгаа нэгдсэн арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцож,

тодорхой ажил хийсэн байна.

Долоо. Дараах газарт согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчлэхийг хориглох

- 7.1.Төрийн болон төрийн бус байгууллагын ажлын байр
- 7.2.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар.
- 7.3.Оюутан сурагчдын хичээлийн болон дотуур байр.
- 7.4.Орон сууцны байр, орц, хонгил.
- 7.5.Гудамж талбай, цэцэрлэг, биеийн тамирын уралдаан тэмцээн, нийтийг хамарсан арга хэмжээ явагдаж буй газар.
- 7.6.Галт тэрэгний буудлын орчин тойронд/татваргүй барааны дэлгүүрээс бусад/ 50 м-ээс бага зайд.

Найм. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих.

8.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд бүх шатны Засаг дарга, ажлын хэсэг, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага, Татварын хэлтэс, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага хууль тогтоомжийн хүрээнд доорх чиглэлээр хяналт тавина. Үүнд:

8.1.1.Сумын Засаг дарга эрх үүргийнхээ хүрээнд гаргасан эрх зүйн актын хэрэгжилт болон нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтэнд

8.1.2.Тусгай зөвшөөрөл, түүний хугацаа хүчинтэй эсэх.

8.1.3.Худалдаа үйлчилгээнд хэрэглэж буй согтууруулах ундаа эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, стандартын шаардлагыг хангасан эсэх.

8.1.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн байршил мөн эсэх, тогтоосон цагийн хуваарийг баримталж байгаа эсэх.

8.1.5.Холбогдох стандартуудын үндсэн шаардлагуудыг хангасан эсэх.

8.2.Сургуулийн сурагч, 21 нас хүрээгүй хүмүүст согтууруулах ундаагаар үйлчилсэн үйлчилгээний байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авна.

8.3.Эрх бүхий албан тушаалтан тухайн аж ахуйн нэгжийн гаргасан зөрчлийн талаар “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний ар талд зөрчлийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулсан байна.

#### Ес. Хариуцлага

9.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газрууд нь дээрх зөрчлүүдийн аль нэгийг гаргасан тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, эрх бүхий албан тушаалтан тусгай зөвшөөрлийн гэрчилгээний ар талд зөрчлийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.

9.2.Зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн аж ахуйн нэгжид хуулийн дагуу хариуцлага тооцно.

9.3.Зөвшөөрөл цуцлагдсан аж ахуйн нэгж, худалдаа, үйлчилгээний цэгт 2 жилийн дотор дахин зөвшөөрөл олгохгүй.



## 10. Бусад

10.1. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь шинээр зөвшөөрөл олгогдсон, хугацаа нь сунгагдсан, зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн хувийг Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэст тухай бүр өгч байна.

10.2. Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын газар, Стандартчилал хэмжил зүйн төв, сумын удирдлага тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн гаргасан зөрчлийн талаарх мэдээлэл болон зайлшгүй шаардлагын улмаас хураагдсан тусгай зөвшөөрлийг тухай бүр ажлын хэсэгт ирүүлнэ.

Энэ журмыг 2016 оны нэгдүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөнө.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 28-ны өдөр      Дугаар 98

Сүхбаатар

**“Ёс төрт гэр бүлийг цогцлоох нь” сэдэвт  
Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан уриалга,  
зөвлөмжийг дэмжих тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санаачлан Хурлын дэргэдэх Ахмадын зөвлөх баг, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, аймгийн Залуучуудын холбоотой хамтран зохион байгуулсан “Ёс төрт гэр бүлийг цогцлоох нь” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчдоос Сэлэнгэ аймгийн төр захиргааны байгууллага, ард иргэд, эцэг эхчүүд, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хамт олонд хандаж гаргасан зөвлөмж уриалгыг дэмжсүгэй.

2.Зөвлөмж уриалгад дэвшүүлсэн ажил арга хэмжээ, санал санаачлагыг дэмжин хэрэгжүүлэхийг аймаг, сумдын Засаг даргад үүрэг болгож, аж ахуйн нэгжи байгууллага, иргэдэд уриалсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын  
28-ны өдрийн 98 дугаар тогтоолын хавсралт

**АЙМГИЙН ИТХ-ААС САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН “ЁС ТӨРТ  
ГЭР БҮЛИЙГ ЦОГЦЛООХ НЬ” СЭДЭВТ ОЛОН НИЙТИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА,  
ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ХАНДАЖ ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ, УРИАЛГА**

Сэлэнгэ аймгийн ИТХ-аас санаачлан Хурлын дэргэдэх Ахмадын зөвлөх баг, аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, аймгийн Залуучуудын холбоотой хамтран зохион байгуулсан “Ёс төрт гэр бүлийг цогцлоох нь” сэдэвт олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчдоос аймгийн төр захиргааны байгууллага, иргэд, эцэг эхчүүд, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хамт олонд хандаж доорхи зөвлөмж уриалгыг гаргаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2014 оны байдлаар 573 хос шинээр гэр бүл болж гэрлэлтээ батлуулан бүртгүүлж, 44 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна.

Энэ цаг үед залуучууд бор зүрхээрээ амьдралд хөл тавьж олон хос орох орон байр, өөрийн гэсэн өмч, эд хогшилгүй хадмын хаяа, айлын хажуу өрөөнд гэр бүл болж байна. Залуучууд гэр бүл болж нэг насны амьдралаа эхлэх хариуцлагатай цаг үед нь эцэг эхийн журамт үүргээр хүлээсэн тусалцаа дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Аав ээж нь голлон ахан дүүс хамаатан садангууд цуглаж нэгдээд хөрөнгө мөнгөө нийлүүлж орон гэр, эд хогшил бэлтгэн хүү, охиныхоо амьдралыг өөдрөг сайхнаар эхлүүлдэг монголчуудын уламжлалт сайхан ёс заншлыг бид эрхэмлэх учиртай.

Хүүгээ гэрлүүлж, охиноо хадамд гаргаж байгаа эцэг эхчүүд сүй тавих, бэр гуйх, гэр орныг бэлтгэх, хурим найр хийх, мал, өмч хөрөнгө тасалж бэлдэж өгөх зэрэг уламжлалт сайхан ёс заншил нь залуу хосын болон худ ургийнхны харилцал ойлголцол, гүн итгэлцлийг бий болгож хоёр талдаа болон олон түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн, ёс журамтай, бат бэх гэр бүлийг цогцлоох үндэс суурь нь болох юм.

Төр засгийн байгууллагууд залуу хосын гэрлэлтийг ёс төртэй, хүндэтгэлтэй бүртгэж баталгаажуулж байх нь тэдэнд урам, ухаарал өгч хариуцлага, ухамсар суулгах ач холбогдолтой гэж үзэн

**БҮХ ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГА НАРТ ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:**

- 1.Аймагт Хүүхэд гэр бүлийн хөгжлийн ордныг гэрлэх ёслолын танхимтайгаар байгуулах, сумдад ёслол хүндэтгэлийн танхим бий болгох.
- 2.Аймгийн хэмжээнд Монгол ёс заншлын өдөртэй болох.
- 3.Монгол гэр бүлийн үүсгэх, хөгжүүлэх уламжлал, ёс заншил, гэр бүлийн харилцаа, хамаарал, ёс төрт гэр бүлийн талаар сургалт сурталчилгааны ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тогтмол зохион

байгуулах.

4.Залуу гэр бүлийг дэмжих тодорхой ажил зохион байгуулах, тэдэнд зориулсан орон сууцны хөтөлбөр гарган хэрэгжүүлэх.

#### **ЭРХЭМ ХҮНДЭТ ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗӨВЛӨЖ УРИАЛАХ НЬ:**

1.Хүүгээ гэр бүл болоход нь орох орон гэр, эд хогшил бэлтгэж өгснөөр залуу гэр бүлийн амьдралын гарааны анхдагч хуримтлал бий болгож өгдөг монгол уламжлал ёс заншлаа сэргээе.

2.Шинээр гэр бүл болж байгаа хүү, охиныхоо хуримын ёслолыг боломжоороо, чадах чинээгээрээ хийж , хоёр тал ураг барилцаж, ах дүү садан төрлөө харилцан танилцуулж, тэдэнд урам ухаарал хайрлан, хамтын амьдралын эхлэлийг нь ёс төртэй тавих.

3.Эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөд нь хүүгийнхээ нэгэнт сонгож хайрласан охин, охиныхоо зөвшөөрч сэтгэлээ өгсөн залууг хүлээн зөвшөөрч, хүндлэн хайрлаж, сургааль зөвлөмжөө хэлж анхнаас нь зөв эерэг уур амьсгал, итгэлцэл бий болгох.

4.Шинэ залуу гэр бүлд хоёр талын аав ээж, ахан дүүсийн алтан сургаал анхаарал халамж хэрэгтэйг болгоож ойр дотно харилцаатай байж, үр хүүхдээ асарч өсгөж бойжуулахад нь эцэг эхийн зөвлөгөө тусламж хэрэгтэйг байнга санаж явах.

#### **АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОНД ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:**

1.Байгууллагадаа ажиллаж байгаа залуучуудыг гэр бүл болоход нь бодитой дэмжлэг туслалцаа үзүүлдэг байх

2.Шинээр гэр бүл зохиосон залуу ажилтнуудаа тогтвортой ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдэхэд анхаарах

3.Байгууллагынхаа залуучуудын амьдрал ахуйг дэмжин урамшуулах хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх.

\_\_\_оОо\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 28-ны өдөр Дугаар 99

Сүхбаатар

**Чойжамцын Жаргалсайханыг Монгол улсын  
Гавьяат багш цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нутгийн захиргааны болон боловсролын байгууллагад тасралтгүй 30 гаруй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, боловсрол, соёлын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, өргөтгөх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд идэвх зүтгэл гарган ажиллаж ирснийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Засаг дарга Чойжамцын Жаргалсайханыг Монгол улсын Гавьяат багш цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 28-ны өдөр

Дугаар 101

Сүхбаатар

### Зөвшөөрөл олгох тухай

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулж үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын 3.7 дахь заалт, 2012 оны 12 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Алтанбулаг сумын 1 дүгээр багт Монголын бурхан шашинтны төв “Гандантэгчэнлин” хийдийн харъяа “Пандэлин” сүм байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд мэдэгдэж, үйл ажиллагааныхаа тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүр ирүүлж байхыг сүмийн ахлагчид зөвлөсүгэй.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 28-ны өдөр Дугаар 102

Сүхбаатар

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Баянгол сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь заалт, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/352 тоот тушаалыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “2015 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай” 145 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “Ерөө сумын нутгаас Баянгол сум түлээний зориулалтаар ойн цэвэрлэгээгээр бэлтгэх 1600 м<sup>3</sup> нарс” гэснийг хасч, “Ерөө сум өөрийн нутгаас цэвэрлэгээний огтлолоор бэлтгэх 1000 м<sup>3</sup> улиасыг Баянгол сум өөрийн нутгаас бэлтгэхээр шилжүүлэн өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалыг газар, Хараа бүсийн сум дундын Ойн ангид даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 18-ны өдөр

Дугаар 105

Сүхбаатар

**Эмийн эргэлтийн санг эрүүл мэндийн төвийн  
харьяалалд шилжүүлэх тухай**

Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын 7.2.2.6 дахь заалт үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эргэлтийн эмийн сангууд болон тэдгээрийн ажилтнуудыг тухайн сум тосгодын эрүүл мэндийн төвүүдийн харьяалалд бүтэц орон тоонд нь багтаан шилжүүлсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 18-ны өдөр Дугаар 106

Сүхбаатар

**Тогтоол хүчингүй болгох тухай**

“Орон нутгийн өмчийн алба, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хувьчлал, дуудлага худалдааны үйл ажиллагааны үр дүн”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын албан шаардлага, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.”Урсгал-Ус” ХХКомпанийн балансад бүртгэлтэй халуун ус, гражийн зориулалттай барилгыг иргэн И.Дэнсмаад менежментийн гэрээгээр эзэмшүүлэх тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 03 дугаар сарын 19-ны 39 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 18-ны өдөр Дугаар 108

Сүхбаатар

**Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар  
худалдах тухай**

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй 1 дүгээр хавсралтад дурьдсан зарим байгууллагын тээврийн хэрэгслүүд, 2 дугаар хавсралтад дурьдсан Сант сумын Засаг даргын тамгын газрын хуучин конторын барилга зэргийг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч, дуудлага худалдааны доод үнийг баталсугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 18-ны  
өдрийн 108 тоот тогтоолын хавсралт 1  
ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ /гөргөөр/

№	Байгууллага аж байхуй нэгж	Хөрөнгийн нэр төрөл	Эд хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтанд орсон он	Тоо ширхэг	Дансны анхны үнэ	Байгуулсан эзлэгдэл	Сэргээгч босголт	Үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	Орон нутгийн өмчийн алба	Засаг даргын санал	Дуудлага хуудлааны үнэ
1	Мандал сум Түнхэл тосгоны Захирагчийн алба	Автомашин	Төбөт Гранд 10-99 СБА	1991	1	14,903,600	14,903,600		0	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	1,000,000
2	Алтанбулаг сумын ЗДТГ	Автомашин	Исузу Бигхорн 82-84 СБА	1996	1	12,210,000	12,210,000		0	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	300,000
3	Хүнс Хөдөө Аж ахуйн газар	Автомашин	Төбөт Ланд круйзер 72-75 СБА	1996	1	26,000,000	19,783,279.7		6,216,720.3	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	6,200,000
4	Хүнс Хөдөө Аж ахуйн газар	Автомашин	УАЗ-469 93-73 СБА	2006	1	13,040,280	13,040,280		0	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	1,500,000
5	Шаамар сумын ЗДТГ	Автомашин	Мицубуши Пахеро 93-77 СБА	1997	1	14,890,000	14,890,000		0	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	1,500,000
6	Зүүнбүрэн сумын ЗДТГ	Автомашин	Төбөт Ланд круйзер 07-08 СЗА	1994	1	14,500,000	12,284,722.3		2215277.7	Актлах	Дуудлага хуудлаа	Дуудлага хуудлаа	2,200,000
	Нийт дүн					95,543,880	87,111,882		8,431,998				12,700,000

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 18-ны  
өдрийн 108 тоот тогтоолын хавсралт 2

ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ /төгрөгөөр/

№	Байгууллага аж ахуй нэгж	Хөрөнгийн нэр төрөл	Эл хөрөнгийн нэр төрөл	Ашиглалтанд орсон он	Тоо ширхэг	Дансны анхны үнэ	Байгуулсан эргэлдэл	Сэргэн бослолт	Үлдэгдэл үнэ	Үндсэн байгууллагын санал	Орон нутгийн өмчийн санал	Засаг даргын санал	Дуудлага худалдааны үнэ
1	Сэлэнгэ аймгийн Сант сумын ЗДТГ	Барилга	Тамын газрын хуучин барилга	1958	1	28,832,000	26,391,196		2,440,804	Ажлаах	Дуудлага худалдаа	Дуудлага худалдаа	20,000,000
	НИЙТ ДУН					28,832,000	26,391,196		2,440,804				

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 03-ны өдөр Дугаар 112

Сүхбаатар

**Худалдааны төвийн талаар авах  
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “в”, 20 дугаар зүйлийн 20.1-д заасныг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд барьж ашиглалтанд оруулсан Худалдааны төвийн барилгыг тоног төхөөрөмжийн хамт орон нутгийн өмчид бүртгэн авч, “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэн өгч эзэмшүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Эрдэнэсайхан/-д даалгасугай.

2.“Худалдааны төвийн үйл ажиллагааны журам” -ыг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 44 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан дүрмийн 4.1.1-д заасны дагуу Худалдааны төвийн үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга /Ж.Сайнцог/ -д даалгасугай.

ДАРГА Ж.САНЖЖАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын  
03-ны өдрийн 112 дугаар тогтоолын хавсралт

## **ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУДАЛДААНЫ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Худалдааны төвийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр эзэмшиж, ашиглах байгууллага, уг төвд гэрээгээр худалдаа, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, харилцааг зохицуулахад оршино.

1.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон Монгол Улсын хууль, тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 44 дүгээр тогтоол нь энэхүү журмын нийтлэг үндэслэл байна.

1.3. Худалдааны төвийг эзэмшиж, үйл ажиллагааг нь эрхэлж, удирдлага зохицуулалтаар хангагч нь “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТ үйлдвэрийн газар / цаашид түрээслүүлэгч гэх / байна.

1.4. Худалдааны төвийн үйлчилгээний танхимын талбай, байр, лангууг худалдаа, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр ашиглуулна.

1.5. Худалдааны төвийн ажиллах цагийн хуваарийг аймгийн Засаг дарга тогтооно.

Хоёр. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг

2.1. Худалдааны төвд худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал, тухайн бараа үйлчилгээний стандартын шаардлага хангасан талаар эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргуулж, түрээслүүлэгчтэй гэрээ байгуулна.

2.2. Өөрийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, стандарт, аймгийн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, шийдвэрийг чанд биелүүлнэ.

2.3. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, ажлын байранд эрүүл ахуй, гоо зүйн шаардлага хангасан хувцас хэрэглэл, таних тэмдэгтэй байна.

2.4. Худалдагч, тогооч, үсчин, зурагчин, засварчны зэрэг тодорхой мэргэжил мэргэшил шаардагдах ажил үйлчилгээ эрхлэгчид мэргэжлийн сургалтанд хамрагдсан, нотлох баримт бичигтэй байна.

2.5. Худалдаа, үйлчилгээнд баталгаат жин хэмжүүр, кассын машин, стандартын шаардлагад нийцсэн сав баглаа, хаяг шошго хэрэглэнэ.

2.6. Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлнө.

2.7. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчид, өөрсдийн хаяг, үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хаяг, нэр төрөл, зар, мэдээллийг монгол хэл дээр үйлдэж байршуулна.

Гурав. Түрээслүүлэгчийн үүрэг

3.1. Худалдааны төвийн барилга, байгууламжийн эзэмшил, ашиглалт, гадна орчин, эзэмшил газрын тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг бүхэлд нь хариуцна.

3.2. Төвд худалдаа, үйлчилгээ эрхлэгчидтэй байр, талбай, лангуу ашиглах түрээсийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангана.

3.3. Түрээсийн төлбөрийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу татан төвлөрүүлэх, зарцуулах харилцааг хариуцан гүйцэтгэж, тайлан тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргана.

3.4. Худалдааны төвд худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн ажиллах нөхцөл, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах, дэг журам сахиулах үүргийг хэрэгжүүлнэ.

3.5. Лангууны байршлыг тогтоохдоо сэлэнгэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс эхлэн эрэмбэлнэ.

3.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлнэ.

#### Дөрөв. Хориглох зүйл

4.1. Хадгалах хугацаа дууссан, чанарын баталгаагүй бараа, бүтээгдэхүүн худалдаалах, үйлчлэхийг хориглоно.

4.2. Төвийн гадна талбайд ил задгай хүнс барааны худалдаа хийхийг хориглоно.

4.3. Зохих зөвшөөрөлгүй согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ хийхийг хориглоно.

4.4. Жинлүүр, туухайн оронд өөр зүйл ашиглахыг хориглоно.

4.5. Үйлчилгээний танхимд төлбөртэй тоглоом, хими цэвэрлэгээ, гэрэл зураг угааж боловсруулах, бүх төрлийн хэвлэх төхөөрөмж ажиллуулахыг хориглоно.

#### Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журам, түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг үл маргах журмаар түрээслүүлэгч тал шууд цуцална.

5.2. Төвд гэрээгээр худалдаа үйлчилгээ эрхлэгч, үйл ажиллагаандаа үйлчилгээний соёл, зан харилцаа, ёс зүйн дутагдал гаргасан, хэрэглэгчийн эрх ашгийг хохироосон тохиолдолд үйл ажиллагааг нь түрээслүүлэгчээс зогсоож, нотлох баримтыг бүрдүүлж хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар 117

Сүхбаатар

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дугаар зүйлийг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 273.1 дэх зорилт, Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7 дахь зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Архидалттай тэмцэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /С.Бүрэнбат/-д даалгасугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 24-ны  
117 дугаар тогтоолын хавсралт

**“АРХИДАЛТТАЙ ТЭМЦЭХ” ХӨТӨЛБӨР**

**Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага,  
өнөөгийн нөхцөл байдал**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх” хөтөлбөр 2003-2012 онд хэрэгжиж дууссан. Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх ажлыг нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр гаргаж байсан зарим дэд хөтөлбөрүүдэд нэг зорилт болгон тусган хэрэгжүүлж ирсэн боловч төдийлэн хангалттай үр дүнд хүрээгүйгээс үүдэн боловсруулж хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газраас батлан гаргасан хууль, тогтоол шийдвэр, баримталж буй бодлого чиглэл, 2015.06.11-ний өдрийн “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 7 дугаар зүйлийн 7.9, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.4, 13<sup>2</sup> 6.2-13<sup>2</sup> 6.6 дахь заалтуудад орсон нэмэлт өөрчлөлт болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015.10.28-ний өдрийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих” журам батлах тухай 97 дугаар тогтоол, Монгол Улсын Эрүүл мэнд, спортын яамны 2015.12.03-ний 1а/4956 тоотой ирүүлсэн “Архигүй Монгол” үндэсний чуулганаас гаргасан зөвлөмж, Засгийн газар, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Архидалттай тэмцэх хөтөлбөр” гаргах зорилтууд зэргийг хэрэгжүүлж, архидан согтуурахтай бүх нийтээрээ тэмцэхээр энэхүү хөтөлбөрийг боловсруулж та бүхэнд танилцуулж байна.

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 11 сарын байдлаар 718 гэмт хэрэг бүртгэгдсэний 36.6 хувь буюу 263 нь согтуугаар үйлдэгдэж энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна. 2015 оны эхний 11 сарын байдлаар аймгийн нутаг дэвсгэрт 40 зоогийн газар, 42 баар, 24 кафе, биллиардын 2 буфет, амралтын газар 10, зочид буудал 1, 265 дэлгүүр буюу нийтдээ 384 цэгт архи согтууруулах ундаа худалдаж, түүгээр үйлчилж улсын хэмжээнд мөрдөхөөр тогтоосон нормативаас давсан хэмжээнд байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгогдсон байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл нийтдээ 69 буюу 2010 онд 26, 2011 онд 13, 2012 онд 4, 2013 онд 1, 2014 онд 15, 2015 оны эхний 11 сарын байдлаар 10 тусгай зөвшөөрөл тус тус олгогдсон байна.

Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийг аттестачлах ажлыг 2013 онд зохион байгуулж 17 сум, 6 тосгоны 346 аж ахуйн нэгж хамрагдаж стандартын шаардлага хангаагүй 83 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг, 2015 оны эхний 11 сарын байдлаар 1 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлаад байна.

Тусгай зөвшөөрөл олголт буурсан үзүүлэлттэй байгаа ч архидан согтуурснаас осол гэмтэл, хүн амын өвчлөл, нас баралт, гэмт хэргийн гаралт, гэр бүл дэх хүчирхийлэл, гэр бүл салалт, сургууль завсардалт зэрэг хүн ам, нийгэмд учирч буй сөрөг нөлөөлөл нэмэгдэж байна.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ, хугацаа**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд **“Архидалттай тэмцэх”** хөтөлбөрийг боловсруулж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх замаар аймгийн хүн амын согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, соён гэгээрүүлэх ухуулга сурталчилгааны ажлыг нэмэгдүүлж, архидан согтуурснаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах эрх зүй, эдийн засаг, нийгмийн орчин бүрдүүлж, архигүй аймаг, сум, баг, байгууллага, хамт олон болоход хөтөлбөрийн зорилго оршино.

### **2.2. Зорилт**

**Хөтөлбөр нь доорх 3 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлнэ. Үүнд:**

**1.”Архигүй аж ахуйн нэгж”** зорилтын дор аж ахуйн нэгж /компани, хоршоо, нөхөрлөл/ бүр архины хор хөнөөлийн соён гэгээрүүлэх ухуулга сургалт, сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагуудтэй хамтран хэрэгжүүлдэг болж, **нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлэн**, эрүүл идэвхтэй амьдралын чиглэлээр хөтөлбөрт тусгагсан 22 ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**2.”Архигүй албан байгууллага”** зорилтын дор албан байгууллага / аймаг, сумын нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны, төрийн үйлчилгээний байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллага/ бүр төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, ажлын байран дээрээ болон аливаа баяр ёслол, албан томилолтоор ажиллахдаа архи, согтууруулах ундаа хэрэглэхээс албан ёсоор татгалзаж, архидалтын эсрэг төлөвлөгөөтэй ажиллаж, архигүй нэгж, хамт олон, байгууллага болох чиглэлээр хөтөлбөрт тусгасан 33 ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**3.”Архигүй айл өрх, иргэн”** зорилтын дор айл өрх, иргэн бүр архи хэрэглэхээс татгалзаж, айл өрх, гэр бүл, улс эх орныхоо хөгжлийн төлөө ажиллаж, амьдрах чиглэлээр хөтөлбөрт тусгасан 6 ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **2.3. Хамрах хүрээ, хугацаа:**

Хөтөлбөр нь аймгийн хэмжээнд хэрэгжиж, аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага,

иргэд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг 2015-2017, 2018-2020 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**Гурав. Хөтөлбөрийн зорилтод хүрэх зарчим, үйл ажиллагааны чиглэл**

**3.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:**

3.1.1."Архидалттай тэмцэх" хөтөлбөр нь хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэндийг хамгаалах, нийтийн дэг журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр гаргасан хууль тогтоомж, дүрэм, журам, хөтөлбөр болон төр, аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан байна.

3.1.2.Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

3.1.3.Иргэд, айл өрх, ажилтан, албан хаагчид архинаас татгалздаг болж, архигүй хамт олон, байгууллага, баг, сум, аймаг болоход чиглэгдэнэ.

**3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

**3.2.1."Архигүй аж ахуйн нэгж" нэгдүгээр** зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

**3.2.1.1.Аж ахуйн нэгж бүр архидалтын эсрэг соён гэгээрүүлэх, ухуулга, сургалт, сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран гүйцэтгэдэг болох**

3.2.1.2.Байгууллага, аж ахуйн нэгжүүд дотооддоо болон нийтэд хүртээмжтэй сургалт, сурталчилгааг санаачлан зохион байгуулах

3.2.1.3.Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй «Эрүүл мэндийг дэмжигч» орчинг бий болгох талаар хамт олны идэвхи санаачлагыг өрнүүлэх, дэмжлэг үзүүлэх;

3.2.1.4.Аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх хөдөлгөөн өрнүүлж, залуучуудын чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх тааламжтай орчинг бүрдүүлэх;

3.2.1.5.Худалдаа, үйлчилгээний байгууллагууд согтууруулах ундааны шил, сав, хайрцаг дээр эрүүл мэндийн анхааруулагүй бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх;

3.2.1.6.Согтууруулах ундааны борлуулалт, хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгаа явуулахаас татгалздаг болох;

3.2.1.7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр санаачлан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй ажиллаж, үр дүнгээ тооцдог болох.

3.2.1.8.Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө хийх ажлын төлөвлөгөөтэй байж, түүнийгээ хэрэгжүүлдэг байх.

3.2.1.9.Байрлаж буй байгууллагын орчныхоо цэвэрлэгээ, хогны асуудлыг шийдвэрлэж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.

3.2.1.10.Үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, үйлчилгээ үзүүлэхдээ хэрэглэгчидээ эрүүл мэндийн сургалт, сурталчилгаанд хамруулдаг болох.

3.2.1.11.Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага гадна, дотно орчны камерын хяналттай болох.

3.2.1.12.Ажлын байранд архи хэрэглэхгүй байх талаар дотоод журамдаа тусгаж, хяналт тавьж, хэрэгжилт үр дүнг тооцож, “Архигүй” хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх

3.2.1.13.Аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг, зөрчил, архидан согтуурахтай тэмцэж, хэрэг зөрчил гаргасан тохиолдолд шалтгаан нөхцлийг арилгуулах, хөдөлмөрийн сахилга батыг чанд сахиулах талаар тодорхой арга хэмжээ авч хэвших.

3.2.1.14.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрхтэй газрууд батлагдан гарсан журам, тогтоогдсон цагийн хуваарийг ягштал мөрдөж, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан согтууруулах ундаагаар зөвхөн насанд хүрсэн хүнд үйлчлэх.

3.2.1.15.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар цагдаа, олон нийтийн цагдаа болон бусад эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

3.2.1.16.Ажиллагсдынхаа зан үйлийг судлан хамт олны чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх талаар тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулж хэвших;

3.2.1.17.Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй арга хэмжээнд идэвхитэй оролцох, боломж нөхцөлөөр хангах, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж, энэ чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах;

3.2.1.18.Архины хамаарлын улмаас эмчилгээ хийлгэсэн хүнийг ажлаа үргэлжлүүлэн хийх, хөдөлмөрийн чадварт нь тохирох ажилд авч ажиллуулах.

3.2.1.19.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллага бүр нь “Архидалттай тэмцэх” ажлыг дэмжигч байгууллага, хамт олон болох.

3.2.1.20.Нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө архины хор уршгийн талаарх мэдээллийн цагийг нэмэгдүүлж, захиалагчдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг болох.

3.2.1.21.Согтууруулах ундааны хэрэглээг дэмжин борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгааг нийтлэхгүй, сурталчлахгүй байхыг эрхэмлэх.

3.2.1.22.Архидан согтуурахаас сэргийлэх талаар тодорхой ажил зохион үр дүнд хүрсэн байгууллага, хамт олны үйл ажиллагааг сурталчилж нийтэд мэдээлдэг болох.

**3.2.2.“Архигүй албан байгууллага” хоёрдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:**

**3.2.2.1.Байгууллага бүр архидалтын эсрэг соён гэгээрүүлэх, ухуулга, сургалт, сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран гүйцэтгэдэг болох.**

3.2.2.2.Согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд явуулах эрүүл мэндийн мэдээлэл,

сургалт, сурталчилгааг өргөжүүлэх

3.2.2.3.Аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх хөдөлгөөн өрнүүлж, залуучуудын чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх тааламжтай орчинг бүрдүүлэх;

3.2.2.4.Архигүй орчинг бий болгох, эрүүл идэвхтэй амьдралыг дэмжсэн үүсгэл санаачлагуудыг дэмжиж, хамтран ажиллах.

3.2.2.5.Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх газруудыг бий болгох.

3.2.2.6.Худалдаа, үйлчилгээний стандартыг чанд мөрдүүлэх.

3.2.2.7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санаачлан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй ажиллаж, үр дүнгээ тооцдог болох.

3.2.2.8.Чөлөөт цагийн болон нийгмийн сайн сайхны төлөө хийх ажлын төлөвлөгөөтэй байж, түүнийгээ хэрэгжүүлдэг байх.

3.2.2.9.Ажлын байрыг архигүй орчин байлгахаар дотоод журамдаа тусгаж, хяналт тавьж, хэрэгжилт үр дүнг тооцож, “Архигүй” хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх.

3.2.2.10.Ажиллагсдынхаа зан үйлийг судлан хамт олны чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээг нэмэгдүүлэх;

3.2.2.11.Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохиож буй арга хэмжээнд идэвхитэй оролцох, боломж нөхцөлөөр хангах, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж, энэ чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах;

3.2.2.12.**Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, сургууль, цэцэрлэг, сургалтын байгууллагууд** гэр бүл, хүүхэд, залуучуудад амьдрах ухааны суурь боловсрол эзэмшүүлэх сургалт явуулах ажлыг жил бүр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллах.

3.2.2.13.Бүх шатны боловсролын байгууллагад архи, тамхи бусад хорт зуршлаас ангид байх орчин бүрдүүлж ажиллах.

3.2.2.14.Хичээлийн чөлөөт цагаар хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл зан үйл төлөвшүүлэхэд үр нөлөө үзүүлэхүйц биеийн тамир, спорт, соёл, урлагийн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, нөхцөл боломжоор хангах, эдгээр арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх;

3.2.2.15.**Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг болон хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулах байгууллагууд** архины асуудалтай хүмүүсийг ажлын байраар хангах, хөдөлмөр зохицуулалт хийх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг өргөжүүлэх;

3.2.2.16.Архидан согтуурснаас хөдөлмөрийн бүтээмж, хамт олны харилцаа, үйлдвэрлэлийн осол гэмтэл, ажил таслалт, боловсон хүчний тогтвор суурьшилд үзүүлж буй сөрөг үр дагаврыг судлан холбогдох арга хэмжээ авч ажиллах;

3.2.2.17.Хилийн болон **Мэргэжлийн хяналтын газар** архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан бусад дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулж үр дүнг тооцох;

3.2.2.18.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад техник, технологи, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.2.19.**Аймгийн Цагдаагийн газар болон хууль сахиулах байгууллагууд** архидан согтуурсны улмаас байнга эрх зүйн зөрчил гаргагчдын судалгааг гаргаж гэр бүл, хамт олонтой нь хамтран ажиллах болон урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;

3.2.2.20.Архи хэтрүүлэн хэрэглэгчид, архинд донтох өвчтэй хүмүүс, орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг болон орон гэргүй архичид, согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж, цахим мэдээллийн сан, сүлжээ бүрдүүлэх

3.2.2.21.Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг эрт илрүүлэхэд чиглэсэн үзлэгийг тогтмолжуулж, удаа дараа хэв журам зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн, тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийг тухай бүр сэтгэц-наркологиин эмчийн үзлэг, шинжилгээнд оруулдаг болгох.

3.2.2.22.Гудамж талбай, олон нийтийн үйлчилгээний газарт хийх хяналт шалгалт, эргүүлийг тогтмолжуулах;

3.2.2.23.Хууль бусаар болон стандартын бус архи худалдсан, үйлчилсэн, насанд хүрээгүй хүнийг уруу татсан, эрүүлжүүлэгдсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэмт хэрэгт холбогдсон сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг сар бүр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг болох.

3.2.2.24.Эрүүл мэндийн байгууллагууд архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж эмчлүүлэх, хяналтад авах арга хэмжээг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллах,

3.2.2.25.Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг шаардлагын түвшинд хүргэх, хамтран ажиллах.

3.2.2.26.Наркологиин албыг бэхжүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2.2.27.Архинаас үүдэн гарах өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх.

3.2.2.28. **Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар** хөтөлбөрийн зарчим, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан жил бүрийн төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.2.29.Стандартын шаардлага хангасан согтууруулах ундааг тодорхой цэгт борлуулах /үйлчлэх/, архи худалддаггүй, үйлчилдэггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагийн тоог нэмэгдүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, үр дүнг тооцох;

3.2.2.30.Байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг

нэг үзүүлэлт болгон сайн ажилласан байгууллага, хамт олныг дэмжин урамшуулж байх.

3.2.2.31.Төрийн бус байгууллагууд нь хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй бүх талаар хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.

3.2.2.32.Архидан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний эрүүл мэнд, ёс зүй, бие сэтгэцэд учруулах хор уршгийн талаар тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

3.2.2.33.Хууль тогтоомжийн хэрэгжилт болон хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, идэвхтэй хамтран ажиллах.

### **3.2.3."Архигүй айл өрх, иргэн" гуравдугаар зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:**

3.2.3.1.Архидалттай тэмцэх талаар аймаг, сум, баг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцогч байх.

3.2.3.2.Архи хэрэглэхгүй байх талаар өөрөө үлгэр жишээ үзүүлж оролцохын дээр бусдад шаардлага тавьж сурах.

3.2.3.3.Замын хөдөлгөөний дүрмийг чанд биелүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцохгүй байх.

3.2.3.4.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, бусдыг шахаж согтоох, насанд хүрээгүй хүнийг уруу татаж согтууруулах ундаа хэрэглэхгүй байх.

3.2.3.5.Гэр бүлийн орчинд, хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэхгүй байж, хүүхэд, залуучуудыг багаас нь эрүүл амьдрах ухаанд сургаж, зөв үлгэр дууриалал үзүүлэх.

3.2.3.6.Иргэний үндсэн болон журамт үүргээ биелүүлж, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр гарсан холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавих.

## **Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт**

### **4.1.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

4.1.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан зөвлөл эрхэлнэ.

4.1.2.Зөвлөл нь аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг жил бүр нэгтгэн дүгнэж аймгийн Засаг даргад тайлагнаж, аймгийн ИТХуралд танилцуулж байна.

4.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сумдад сумын Засаг даргаар ахлуулсан салбар зөвлөл гүйцэтгэнэ.

4.1.4.Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд эл үүргийг тэдгээрийн удирдлага ахалсан салбар зөвлөл хариуцна.

### **4.2 Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

4.2.1.Иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэнээс үзүүлсэн хандив, тусламжийн хөрөнгө.

4.2.2. Хууль тогтоомжийн хүрээнд олгох төсвийн хөрөнгө.

4.2.3.Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдээс нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр бүрдүүлсэн хөрөнгө

## **Тав.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

### **5.1 Хяналт үнэлгээ**

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх ажлыг аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

### **5.2.Хөтөлбөрийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:**

5.2.1. Согтууруулах ундааны эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтэд тавих хяналтын үзүүлэлт

1	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2015 он)	Завсрын үзүүлэлт (2017 он)	Эцсийн үзүүлэлт (2020 он)
1	Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөр, цагийг тоог нэмэгдүүлэх	Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдөртэй болсон.	1/Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдрийн тоог нэмэгдүүлнэ.	Согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй сар, өдрийн тоо нэмэгдсэн байна.
2	Согтууруулах ундаа худалддаг болон үйлчилдэг цэгийн тоог бууруулах	265+119=384	Хууль, журмын дагуу цөөрүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ.	Хуульд нийцсэн тоо хэмжээнд хүрсэн байна.
3	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олголт	Жилд 1-26 хүртэл тусгай зөвшөөрлийг олгож байна.	Хууль, журам зөрчсөн аж ахуйн нэгжид дахин тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.	Хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрлийг олгодог болно.
4	Эрүүлжүүлэгдсэн хүний тоог бууруулах.	3362	5-20 хүртэл хувиар бууруулна.	20-иос дээш хувиар буурсан байна.
5	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтыг бууруулах.	263	15 хүртэл хувиар бууруулна.	15-аас дээш хувиар бууруулсан байна.



Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

6.1.Хууль эрх зүйн орчны шинэчлэлтэй холбогдуулан гарсан хуулийн болон хөтөлбөрийн хэрэгжилт, согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавих хяналт сайжирч, тусгай зөвшөөрөл олгох журам шинэчлэгдэж, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоог хуульд заасан хэмжээ хязгаар, тогтоосон хэмжээнд хүргэсэн байна.

6.2.Бүх сум согтууруулах ундаа худалддаггүй, хэрэглэдэггүй өдөр, цагийн тоог тоог нэмэгдүүлсэн байна. /Тухайлбал өглөө 8-9 цаг, өдөр 13-14 цаг, орой 17-18 цагууд болон өвөл, зуны цагийн хязгаарлалттай болох гм/

6.3.Архины асуудалтай хүмүүст урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналтанд авах анхан шатны тусламж, үйлчилгээг сум, өрхийн эмнэлэг үзүүлдэг болж, архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих, нийгэм хамт олонд тулгуурласан эрүүл мэнд, нийгмийн тусламж, үйлчилгээ буй болж чанар хүртээмж нь нэмэгдсэн байна.

\_\_\_оОо\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар 118

Сүхбаатар

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 156 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Орон нутгийн байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгоход мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 24-ны  
өдрийн 118 тоот тогтоолын хавсралт

## **ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫГ ГАВЬЯАТ ҮЙЛСТНИЙ НЭРЭМЖИТ БОЛГОХОД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.Орон нутгийн байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгоход Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 156 дугаар тогтоолоор баталсан журам, түүнд нийцүүлэн гаргасан энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Гавьяат үйлстэн

2.Гавьяат үйлстэнд дараах хүмүүсийг хамааруулан ойлгоно.

2.1.Монгол улсын баатар, Монгол улсын хөдөлмөрийн баатар

2.2.Монгол улсын ардын болон гавьяат цолтон

2.3.Шинжлэх ухааны академийн гишүүн, нэрд гарсан эрдэмтэн

2.4.Тухайн аймаг, сумын даргаар 12-оос доошгүй жил ажиллаж, хийж бүтээснээрээ нутгийн иргэдийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн алдартан

Гурав. Орон нутгийн байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгох

3.1.Орон нутгийн байгууллага гэж орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр байгуулагдсан, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон орон нутагтаа үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагыг хэлнэ.

3.2.Орон нутгийн байгууллагыг нэрэмжит болгох гавьяат үйлстэн нь тухай байгууллагын түүх, ажил амьдралтай холбоо хамааралтай эсэхийг харгалзан үзвэл зохино.

3.3.Гавьяат үйлстний мэндэлсний 70 болон түүнээс дээших 10 жилийн давтамжтай тэгш ойг нь тохиолдуулан орон нутгийн байгууллагыг түүний нэрэмжит болгож болно.

3.4.Байгууллагыг гавьяат үйлстний нэрэмжит болгох санал, хүсэлтийг сумын Засаг даргад гаргах бөгөөд сумын Засаг дарга судлан үзэж тухай байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

3.4.1.Нэрэмжит болгох хүсэлт

3.4.2.Гавьяат үйлстний намтар, танилцуулга, тухайн байгууллагыг түүний нэрэмжит болгох үндэслэл

3.4.3.Нэрэмжит болгох байгууллагын танилцуулга, хамт олны хурлын тэмдэглэл

3.4.4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын санал

3.5.Аймгийн Засаг дарга энэ журмын 3.3-т заасан хүсэлт, баримт бичгийг хянан үзэж 30 хоногийн дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

3.6.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид орон нутгийн байгууллагыг нэрэмжит болгох асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана.

3.7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ журмын 3.1-д заасан орон нутгийн байгууллагаас бусад байгууллагыг нэрэмжит болгох саналыг тухай асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Монгол улсын Засгийн газарт уламжлан хүргүүлнэ.

3.8.Гавьяат үйлстний нэрэмжит болсон байгууллага нь тухай гавьяат үйлстний алдар гавьяа, амжилт бүтээлийг олон түмэнд сурталчлан таниулж, үйл хэргийг мөнхжүүлэн нэр төртэй авч явах бөгөөд түүний гэр бүл, үр хүүхдүүдтэй холбоотой байж хамтран ажиллана.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар 119

Сүхбаатар

**Журам батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.3.б, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн “Нийтийн эзэмшлийн байгууламжийн харилцааг зохицуулах” журмыг хавсралтаар баталсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын  
24-ний өдрийн 119 тоот тогтоолын хавсралт

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журам нь Сэлэнгэ аймаг дахь нийтийн эзэмшлийн байгууламжийн эд хөрөнгийн эзэмших, ашиглах, арчлах, хамгаалах, хөдөлгөх гэх мэт харилцааг зохицуулна.

1.2.Журмыг тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд бүх нийтээр дагаж мөрдөнө.

1.3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өөрийн орон нутгийн онцлогт тохирсон журам боловсруулан мөрдүүлж болно.

### **ХОЁР. НЭР, ТОМЪЁО**

2.1.“Нийтийн эзэмшлийн байгууламж ” гэж гол, горхи, булаг шанд орчмын Улсын болон орон нутгийн хөрөнгөөр бий болсон ногоон бүс, тухайлсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршоолол, төрийн бус байгууллагад зориулагдаагүй, тухайн орон нутгийн иргэдэд нийтээр ашиглах боломжтойгоор орон нутгийн болон улсын төсөв, төсөл хөтөлбөр, хандив, тусламжийн хөрөнгөөр бий болгосон усан оргилуур, явган хүний болон автомашины зам, талбай, сүүдрэвч, самбар, хашаа, хайс, хогийн сав, мод, сөөг, зүлэг, бүхий ногоон байгууламж, спортын, чийрэгжүүлэлтийн, хүүхдийн тоглоомын, амралт чөлөөт цагийн болон наадмын талбай, гудамжны камер, замын гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэгээ, гүүр, хөшөө, түүх дурсгалын газар гэх мэт эд хөрөнгийг ойлгоно.

2.2.“Өмчлөгч” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийг захиран зарцуулах, шинээр олж авах, шилжүүлэх, эрхийг эдэлж байгаа тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал байна.

2.3.“Эзэмших” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн эд хөрөнгийг өмчлөх эрх бүхий байгууллагын шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн данс бүртгэлд тусгаж, хадгалалт, хамгаалалтыг нь хариуцана.

2.4.“Ашиглах” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн тодорхой хэсгийг өмчлөгч болон эзэмшигчийн зөвшөөрлөөр төлбөртэй болон төлбөргүйгээр гэрээгээр хариуцахыг хэлнэ.

2.5.“Арчлах” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн чанар, өнгө үзэмжийг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх засвар үйлчилгээ, усалгаа, арчлалт , тордолт хийхийг хэлнэ.

2.6.“Хамгаалах” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн хэвийн ажиллагаа, чанарыг алдагдуулахгүйгээр хадгалахыг хэлнэ.

2.7.“Хөдөлгөх” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн байршил, чанар зориулалтыг нь өөрчлөх, түр хугацаанд хэвийн ажиллагааг нь зогсоох зэрэг үйлдлийг хэлнэ.

2.8. “Гэмтээх” гэж ногоон байгууламж, мод сөөг, талбай, явган хүний зориулалттай зам зэрэг нийтийн зориулалттай эд хөрөнгийн чанарыг алдагдуулах, гэмтээх, зам талбай сэтлэх, газар шорооны ажил хийх, бохирдуулах, дээгүүр нь автомашин тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр зорчих, мал амьтан бэлчээх, зөвшөөрөлгүйгээр реклам, сурталчилгааны самбар байрлуулах, мэдээлэл наах гэх мэт нийтийн эзэмшлийн байгууламжийн өнгө үзэмж, чанар, хэвийн ажиллагааг алдагдуулсан аливаа үйлдлийг хэлнэ.

2.9. “Нийтийн эзэмшлийн байгууламжийн нөхөн төлбөр” гэж тухайн эд хөрөнгийн гэмтлийг арилгуулахтай холбоотой биет бус үнэлэх боломжгүй зардал, мөн эд хөрөнгө эвдэрч гэмтсэнээс болж чанар нь мууддаг тул уг алдагдлыг нөхөх, хэвийн ажиллагаа алдагдсанаас болж ажиллагаа нь зогссон үеийн өртөг зэргийг тооцсон зардлыг хэлнэ.

2.10. “Нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэлийн дэвтэр” гэж нийтийн эзэмшлийн байгууламжийн эд хөрөнгийн нэр төрөл, тоо, хэмжээ, үнэ өртөг, ашиглалтанд орсон огноо, засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтуудын эх үүсвэр зэргийг тусгасан бүртгэлийг хэлнэ.

## **ГУРАВ. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХАРИЛЦАА**

3.1. Аймгийн Орон нутгийн өмчийн алба нь нийтийн эзэмшлийн байгууламжтай холбоотой журам, тогтоол шийдвэрт хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

3.2. Нийтийн эзэмшлийн байгууламжийг Аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн албаны саналыг үндэслэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр төсөвт байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад эзэмшүүлнэ.

3.3. Нийтийн эзэмшлийн байгууламжийг эзэмшигч байгууллага нь уг байгууламжийн доорх газрыг өөр этгээдэд эзэмшүүлэхгүй байх үүрэгтэй.

3.4. Эзэмшигч байгууллагын зөвшөөрлөөр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийтийн эзэмшлийн байгууламжийн тодорхой хэсгийг гэрээгээр хугацаатайгаар ашиглуулж болно.

3.5. Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчлах, хамгаалах ажлыг эзэмшигч байгууллага хариуцах бөгөөд гэрээний үндсэн дээр ашиглагч байгууллагад 1 жилээс илүүгүй хугацаатайгаар хариуцуулж болно.

3.6. Нийтийн эзэмшлийн байгууламжийн тоо, чанарыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг арчлах зардлын хамт шийдвэрлэдэг байх.

3.7. Нийтийн эзэмшлийн байгууламжийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр Орон нутгийн өмчийн албаны зөвшөөрлөөр гэрээний үндсэн дээр хөдөлгөнө.

3.8. Нийтийн эзэмшлийн байгууламжийг хөдөлгөх зардлыг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

3.9. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн нийтийн эзэмшлийн байгууламжийг арчлах зориулалттай тоног төхөөрөмж, машин механизмыг төсөвт болон орон нутгийн өмчийн байгууллагуудад тухайн зориулалтаар нь гэрээгээр үнэ төлбөргүйгээр ашиглуулж болно.

## **ДӨРӨВ. БУСАД**

4.1.Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчлалт, ашиглалт, хамгаалалтанд тухайн нутгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, багийн засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Цагдаагийн байгууллага, Олон нийтийн цагдаа, эзэмшигч байгууллагын удирдлагууд хяналт тавина.

4.2.Нийтийн эзэмшлийн байгууламжийн бусад газар эзэмшүүлэх асуудлыг Орон нутгийн өмчийн албатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

4.3.Нийтийн эзэмшлийн байгууламжийн арчлалт, ашиглалт, хамгаалалтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төлбөр хураамж авч болох бөгөөд төлбөр хураамжийн хэмжээг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

## **ТАВ. ХАРИУЦЛАГА**

5.1.Энэ журмын 3.8-ийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар зөрчлийг бүрэн арилгуулж, зөрчилтэй холбоотой зардлыг төлүүлнэ.

5.2.Нийтийн эзэмшлийн байгууламжийг гэмтээсэн мал амьтныг тусгай хашаанд түр саатуулан эзнийг нь тодруулж, хохирол болон түүнтэй холбоотой зардлыг төлүүлэх ба эзэн нь олдохгүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж асуудлыг шийвэрлүүлнэ.

5.3.Насанд хүрээгүй хүүхэд нийтийн эзэмшлийн байгууламжийн эд хөрөнгийг гэмтээсэн бол эцэг эх, асран хамгаалагчаар нь түүнтэй холбогдон гарах зардлыг төлүүлнэ.

5.4.Нийтийн эзэмшлийн байгууламжинд зөвшөөрөлгүй зорчсон тээврийн хэрэгслийг саатуулж, хохирлыг барагдуулна.

5.5.Өмчлөгч, эзэмшигчийн үүргээ биелүүлээгүй албан тушаалтан, байгууллагын даргад эрх бүхий албан тушаалтан хариуцлага тооцно.

5.6.Нийтийн эзэмшлийн байгууламжинд хохирол учруулсан тохиолдолд буруутай этгээдэд эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ тооцохоос гадна хохирлыг барагдуулах ба барагдуулаагүй тохиолдолд хохирлын зардлыг анхан шатны баримт, зах зээлийн ханш хоёрын өндөр өртгөөр нь тогтоож, уг зардлыг 2 дахин нугалж төлүүлэх ба уг төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

5.7.Нийтийн эзэмшлийн байгууламжтай холбоотой зөрчилд аймгийн Орон нутгийн өмчийн алба, тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, эзэмшигч байгууллагын удирдлагууд хяналт тавиж төлбөр төлүүлнэ.

5.8.Энэхүү журмыг аймагт нийтээрээ дагаж мөрдөх ба журамтай холбоотой аливаа маргаантай асуудлыг хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.



**ЗУРГАА. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН  
БАЙГУУЛАМЖАД ХАМААРАХ ЗҮЙЛС**

- 1.Бут сөөг /байршил нэрээр /ш/
- 2.Шилмүүст мод /байршил нэрээр /ш/
- 3.Навчит мод /байршил нэрээр /ш/
- 4.Хайс хашлага /байршил нэрээр /явган, м2/
- 5.Ургамлын хашлага байршил нэрээр /бургас, уртааш метр/
- 6.Биеийн тамирын талбай /байршил нэрээр /м2/
- 7.Сагсны иж бүрэн самбар /байршил нэрээр /ш/
- 8.Тоглоомын талбай /байршил нэрээр /м2/
- 9.Сүүдрэвч /байршил нэрээр /төмөр, модон, ш/
- 10.Сандал /байршил нэрээр /төмөр, ширмэн, ш/
- 11.Бетонон авто зам /байршил нэрээр /км/
- 12.Бетонон явган зам /байршил нэрээр /км/
- 13.Хатуу хучилттай авто машины зогсоол /байршил нэрээр /м2/
- 14.Шороон хучилттай авто машины зогсоол /байршил нэрээр /м2/
- 15.Гүүрэн гарц /байршил нэрээр/уртааш метр/
- 16.Шороон нийтийн зориулалттай талбай /байршил нэрээр /м2/
- 17.Асфальтан нийтийн зориулалттай талбай /байршил нэрээр /м2/
- 18.Бетонон нийтийн зориулалттай талбай байршил нэрээр /м2/
- 19.Хорооллын гэрэлтүүлгийн асаах унтраах төв /байршил нэрээр/
- 20.Гэрэлтүүлгийн шон /байршил нэрээр /ш/
- 21.Шороон үерийн далан, суваг /байршил нэрээр /уртааш метр/
- 22.Бетон хучилттай үерийн далан, суваг /байршил нэрээр /уртааш метр/
- 23.Самбар /байршил нэрээр /м2/
- 24.Гудамжны камер /байршил нэрээр /ш/
- 25.Түүх дурсгалын газар /байршил нэрээр /ш/
- 26.Хөшөө /байршил нэрээр /ш/
- 27.Замын гэрлэн дохио /байршил нэрээр /ш/
- 28.Замын тэмдэг тэмдэглэгээ /байршил нэрээр /ш/
- 29.Усан оргилуур /байршил нэрээр/
- 30.Гудамжны хогийн сав /байршил нэрээр /ш/

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар 122

Сүхбаатар

**Д.Оюунсүрэнг Монгол улсын  
Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Соёл урлагийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, драмын урлагийг хөгжүүлэхэд авьяас чадвараа дайчлан ажиллаж драмын урлагт мэргэжлийн олон уран бүтээлчдийг бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Сант сумын харьяат жүжигчин, найруулагч, Их засаг их сургуулийн Театр урлагийн сургуулийн захирал Дамдинсүрэнгийн Оюунсүрэнг Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар 126

Сүхбаатар

**Зөвшөөрөл олгох тухай**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулж үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ын 3.7 дахь заалт, 2012 оны 12 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ерөө сумын Тавин 1 дүгээр багт “Зурхай засал гэгээрүүлэх дацан” байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Сүмийн дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд мэдэгдэж, үйл ажиллагааныхаа тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүр ирүүлж байхыг сүмийн ахлагчид зөвлөсүгэй.

**ДАРГА Ж.САНЖЖАВ**